



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

УИХ-ын Төсвийн Байнгын хорооны санал, ҮАГ-ын төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХУУРАМЧААР ГАРГАЖ, САНХҮҮЖИЛТ АВАХ ЗӨРЧИЛ ИХЭСЧЭЭ



Улсын төсөв, МУХС-гийн төсвийн хөрөнгөөр 2009 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилт

<p style="text-align: center;"><u>Тайланг бэлтгэсэн:</u></p> <p>ҮАГ-ын Гүйцэтгэлийн аудитын газар</p> <p><i>Захирал</i> <i>Д.Ганбилэг</i></p> <p><i>Аудитын менежер</i> <i>Х.Баярмаа</i></p> <p><i>Ахлах аудитор</i> <i>С.Сэрчхорол</i> <i>Г.Цэдэнбалжир</i> <i>Ц.Гэрэл</i></p> <p><i>Аудитор</i> <i>З.Ариунзаяа</i> <i>Г.Гүнжидмаа</i> <i>Д.Болормаа</i></p> <p><i>Шинжээч</i> <i>Б.Болормаа</i> <i>Р.Цолмон</i> <i>Ш.Энхтайван</i> <i>Б.Саруул</i> <i>Ц.Эрдэнэчулуун</i></p> <p>2010 оны 6 дугаар сар</p> <p>Уг тайланг ҮАГ-ын вэб сайт-аас үзнэ үү:</p> <p><u>www.mnao.mn</u></p> <p><i>Аудитын тайлантай холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261885, 263755 дугаарын утас, 323266 дугаарын факсаар харилцана уу.</i> ХАЯГ: <i>Үндэсний аудитын газар Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-6, Улаанбаатар-46, Зипкод-15160 Монгол Улс</i></p>	<p>Товчилсон үгсийн жагсаалт 2</p> <p>Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй 3</p> <p>Бүлэг 1 Гүйцэтгэгчтэй хийсэн гэрээнд зайлшгүй шаардлагатай зарим нөхцлийг тодорхой тусгаагүй байна</p> <p>Ерөнхий мэдээлэл 5</p> <ul style="list-style-type: none"> • Худалдан авах ажиллагааны аргыг холбогдох журмын дагуу сонгоогүй байна 6 • Хууль зөрчин гүйцэтгэгчийг шалгаруулжээ 7 • Хөрөнгө оруулалтын гэрээнд зарим гол нөхцлийг тодорхой заахгүй байна 8 <p>Бүлэг 2 Ажлын гүйцэтгэлийг хуурамчаар гаргаж санхүүжилт авах зөрчил арилахгүй байна</p> <ul style="list-style-type: none"> • Гүйцэтгэл дутуу байхад санхүүжилтийг бүрэн олгожээ 10 • Хөрөнгө оруулалтын ажлыг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгээгүй байна 12 • Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд тавих явцын хяналт хангалтгүй байна 13 • Хөрөнгө оруулалтын зориулалтыг өөрчилжээ 14 • Үнийн өсөлтөөр нэмэгдсэн зардлыг олгохдоо төсвийн ерөнхийлөн захирагч нарт харилцан адилгүй хандсан байна 15 <p>Бүлэг 3 Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээг бүрэн ашиглахгүй байна</p> <ul style="list-style-type: none"> • Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг үнэн зөв гаргаагүй байна 17 • Төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна 17 • УИХ-ын гишүүдийн орон нутагт хэрэгжүүлэхээр санал болгосон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн 96.0 хувь нь зарцуулагджээ 18 • Дүгнэлт 22 • Холбогдох байгууллагын санал 23 • Зөвлөмж 29
--	---

Товчилсон үг

УИХ	Улсын Их Хурал
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
ЗГХЭГ	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
БОАЖЯ	Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БСШУЯ	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
ГХЯ	Гадаад хэргийн яам
НХХЯ	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЗТБХБЯ	Зам тээвэр, барилга, хот байгуулалтын яам
ЭБЭХЯ	Эрдэс баялаг, эрчим хүчний яам
БХЯ	Батлан хамгаалах яам
ҮТЕГ	Үндэсний татварын ерөнхий газар
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
МХХТГ	Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар
МУХС	Монгол Улсыг хөгжүүлэх сан
БЗА	Барилга захиалагчийн алба
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТБУСТХ	Төсвийн байгууллага, удидлага санхүүжилтийн тухай хууль
ТНЖБТХ	Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль
БТХ	Барилгын тухай хууль
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НБХБТГ	Нийслэлийн барилга, хот байгуулалт төлөвлөлтийн газар

ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ЦДАШ	Цахилгаан дамжуулах агаарын шугам
ЭХБУ	Эрчим хүчний барилга угсралт
ОУНБ	Олон улсын нисэх буудал
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
ОХУ	Оросын Холбооны Улс
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
УМХГ	Улсын мэргэжлийн хяналтын газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
НМХГ	Нийслэлийн мэргэжлийн хяналтын газар
СЭЗХ	Санхүү, эдийн засгийн хэлтэс
ХОАҮГ	Хөрөнгө оруулалт, ашиглалт үйлчилгээний газар
НОБГ	Нийслэлийн онцгой байдлын газар
СХД	Сонгинохайрхан дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
ЧД	Чингэлтэй дүүрэг

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хорооны санал, Монгол Улсын Ерөнхий аудитор ТҮАГ-аас 2010 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийв.

Аудитын зорилт

Улсын төсөв, МУХС-гийн хөрөнгөөр 2009 онд санхүүжүүлсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг шалгаж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг хангахын тулд дараахь чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Гүйцэтгэгчийг оновчтой сонгосон эсэх;
- Хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг үнэлж, холбогдох арга хэмжээ авсан эсэх;
- Хөрөнгө оруулалтыг бүртгэлд тусгасан эсэх

Хамарсан хүрээ, хугацаа

Аудитад төсвийн ерөнхийлөн захирагчдын төсвийн багц болон холбогдох агентлаг, газруудын 2009 оны 1 дүгээр сарын 1-нээс 12 дугаар сарын 31 хүртэлхи хугацааны хөрөнгө оруулалтын санхүүгийн үйл ажиллагаа хамрагдав.

Арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ Төрийн хяналт шалгалтын стандарт, түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, гүйцэтгэлийн аудитын гарын авлага, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу дараахь арга зүйг ашиглав. Үүнд:

- Монгол Улсын 2009 оны төсвийн болон МУХС-гийн төсвийн тухай хууль, төсвийн тодотголоор батлагдсан хөрөнгө оруулалтын судалгаа, материалыг гаргуулан авч харьцуулах;
- Улсын төсөв, МУХС-гийн төсвийн хөрөнгөөр 2009 онд хийсэн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, гүйцэтгэлд дүн шинжилгээ хийх;
- ТБОНӨХБАҮХАТХуулийн хэрэгжилтийг ТЕЗ-дын багцын хүрээнд түүвэрлэн шалгах;
- Орон нутагт хийгдсэн хөрөнгө оруулалтын хэрэгжилтийн талаар аймгийн аудитын газруудтай хамтран түүвэрлэн судалж үзэх;
- Сангийн яам болон холбогдох бусад байгууллагын ажилтнуудтай ярилцлага хийж, тодруулга авах;
- IDEA програм ашиглаж хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн тендерт шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалтыг гаргаж дүгнэх.

Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын журамд заасны дагуу аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Бүлэг 1

ГҮЙЦЭТГЭГЧТЭЙ ХИЙСЭН ГЭРЭЭНД ЗАЙЛШГҮЙ ШААРДЛАГАТАЙ ЗАРИМ НӨХЦӨЛИЙГ ТОДОРХОЙ ТУСГААГҮЙ БАЙНА

Ерөнхий мэдээлэл

1.1 Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хуулиар хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид олгох санхүүжилтийг 409141.3 сая, МУХС-гийн 2009 оны төсвийн тухай хуулиар санхүүжүүлэх хөрөнгө оруулалтыг 122289.3 сая, нийт 531430.6 сая төгрөгөөр баталсан байна.

1.2 2009 оны Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх хөрөнгө оруулалтаас 167388.4 сая төгрөг хасч, 241752.9 сая, харин МУХС-гийн төсвийн хөрөнгөөр санхүүжигдэх хөрөнгө оруулалтыг 44345.0 сая төгрөгөөр нэмж 166634.3 сая, нийтдээ 408387.2 сая төгрөгөөр баталжээ.

1.3 МУХС-гийн төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар авто зам, барилга, эрчим хүчний салбарт 2008 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтөөр нэмэгдсэн зардлын хэмжээг 12866.8 сая төгрөгөөр баталсан байна.

1.4 Улсын төсөв, МУХС-гийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийг төсвийн ерөнхийлөн захирагчдаар ангилж харуулбал,

(сая төгрөгөөр)					
№	Салбар	Улсын төсөв	МУХС	Нийт дүн	Нийт дүнд эзлэх хувь
1	ЗТБХБС	72695,3	66567,0	139262,3	34,1
2	ЭБЭХС	18190,0	28520,3	46710,3	11,4
3	БСШУС	44916,1	1145,0	46061,1	11,3
4	ХХААХҮС	605,6	30300,0	30905,6	7,6
5	НЗД	13351,3	11090,0	24441,3	6,0
6	ЭМС	21729,2	500,0	22229,2	5,4
7	НХХС	386,0	21134,7	21520,7	5,3
8	ШС	18442,8	1500,0	19942,8	4,9
9	СС	16350,0		16350,0	4,0
10	ТШС	11973,9	3300,0	15273,9	3,7
11	ХЗДХС	7370,5		7370,5	1,8
12	ГХС	2993,0	2000,0	4993,0	1,2
13	ЕС	4198,3		4198,3	1,0
14	БОАЖС	2577,0		2577,0	0,6
15	БХС	2024,9		2024,9	0,5
16	ЗГХЭГ-ын дарга	1589,0		1589,0	0,4
17	ҮХЦ-ийн дарга	930,0		930,0	0,2
18	УИХ-ын дарга	180,0	577,3	757,3	0,2
19	ҮСХ-ны дарга	500,0		500,0	0,1
20	АТГ-ын дарга	384,0		384,0	0,1
21	ШЕЗ-ийн дарга	321,0		321,0	0,1
22	УЕП	35,0		35,0	0,0
23	Улсын ЕА	10,0		10,0	0,0
Нийт дүн		241752,9	166634,3	408387,2	100

1.5 Дээрх судалгаанаас харахад нийт хөрөнгө оруулалтын 45.5 хувийг дэд бүтцийн салбарт, 22.0 хувийг нийгмийн салбарт, 7.6 хувийг хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн салбарт, 6.0 хувийг НЗДТГ-т, 18.9 хувийг бусад салбарт зарцуулахаар төлөвлөжээ.

1.6 Улсын төсөв, МУХС-гийн хөрөнгөөр 2009 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт өмнөх оноос 110434.6 сая төгрөгөөр буюу 21.3 хувиар буурсан байна.

1.7 Улсын төсөв, МУХС-гийн төсвийн хөрөнгөөр 2009 онд санхүүжигдэх хөрөнгө оруулалтыг зориулалтаар нь ангилж үзэхэд нийт хөрөнгө оруулалтын 91.8 хувь хөрөнгө оруулалтын чанартай арга хэмжээнд, 5.4 хувь тоног төхөөрөмж худалдан авахад, 2.8 хувь их засварын ажилд төлөвлөгдсөн байна. (Хавсралт №1)



Худалдан авах ажиллагааны аргыг холбогдох журмын дагуу сонгоогүй байна

1.8 2009 онд улсын хэмжээнд нийт 400 тендер зарлагдсаны 224-ийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 164-ийг тендер шалгаруулалтын онцгой журмын дагуу шалгаруулжээ. Үүнийг салбараар ангилан харуулбал:

(сая төгрөгөөр)

ТЕЗ-ийн нэр	Тендерийн тоо	Нээлттэй		Тендер шалгаруулалтын онцгой журам					
				Хязгаарлагдмал		Харьцуулалт		Шууд гэрээ	
		тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
БОАЖС	32	6	325.3	1	1969.0	18	320.5	7	388.0
НХХС	30	15	21246.3					15	50.0
БХС	9	4	207.3			2	20.4	3	877.5
ЭМС	33	28	6937.0			5	177.0		
ГХС	7					7	350.0		
ЗТБХБС	22	10	27099.2	10	1000.0	1	46.3		
УИХ	15	6	476.0			3	18.3	6	261.2
ШС	22	9	1642.4			11	48.9	2	49.5
ХЗДХС	32	5	838.3	4	47.6	5	89.9	18	6394.7
ХХААХҮС	39	39	30300.0						
УПЕ	1	1	34.4						
БСШУС	42	40	23526.0			2	34.9		
СС	30	15	6111.3			13	463.2	2	4.3
ЭБЭХС	32	31	44873.7			1	45.0		
ЗГХЭГ	30	3	489.0	1	140.0	18	640	8	320.0
ТШС	12	11	1473.9	1	1000.0				
ҮСХ	12	1	276.8			11	223.3		
Нийт дүн	399	224	165856.9	17	4156.6	97	2477.6	61	8345.2

1.9 2009 оны нийт худалдан авалтын 15.3 хувийг шууд гэрээ байгуулах замаар гүйцэтгэгчийг сонгожээ.

1.10 Гүйцэтгэгч сонгон шалгаруулсан байдлыг авч үзэхэд хуулиар тогтоосон босго үнээс дээш төсөвт өртөгтэй буюу нээлттэй тендер шалгаруулалт болон

харьцуулалтын аргаар хэрэгжүүлэх худалдан авах ажиллагааг шууд гэрээ байгуулсан, тендер зарлалгүйгээр худалдан авсан зэрэг зөрчил илэрч байна. Үүнд:

- 2009 онд Улаанбаатар хотын гэр хорооллын цахилгаан эрчим хүчинд холбогдоогүй айл өрхийг эрчим хүчээр хангах, хүчдэл сайжруулахад нийт 8000,0 сая төгрөгийг НЗДТГ, НБХБТГ-аар дамжин зарцуулахаар төлөвлөгдсөн ба гүйцэтгэлээр 7810,5 сая төгрөг зарцуулсан байна. Үүнийг хэрэгжүүлэхийн тулд: НБХБТГ-аас 2009 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр нээлттэй тендер зарлаж 9 компани, 2009 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр харьцуулалтын аргаар тендер зарлан 16 компанитай гэрээ байгуулсан боловч хугацааны хувьд боломжгүй болсон тул шууд гэрээ байгуулан барилга угсралтын ажлыг эхлүүлжээ.
- 2009 онд ЗТБХБ –ын салбарын бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөнд тусгагдсан 16 төсөл, арга хэмжээнээс 6-д нь тендер зарлаагүй байна.
- Цөмийн энергийн газар 250.0 сая төгрөгийн компьютер, дагалдах хэрэгсэл, тавилга эд хогшил, МХХТГ 64.0 сая төгрөгийн автомашин болон автобус, 2 ш сервер компьютерыг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар худалдан авах ёстой атал ТБОНӨХБАУАТХуулийн 8.1, 8.4, 8.5 дахь заалтыг зөрчин харьцуулалтын арга ашигласан байна.

1.11 ТНЖБТ, ТБОНӨХБАУАТХуулийн 3.3-т заасны дагуу БХЯ, ЦЕГ, ХХЕГ, ШШБЕГ, АТГ тусгай хэрэгсэл, тоног төхөөрөмж, ажил үйлчилгээг худалдан авах ажиллагааг шууд гэрээгээр гүйцэтгэсэн учир аудитад хамрагдаагүй болно.

Хууль зөрчин гүйцэтгэгчийг шалгаруулжээ

1.12 Улсын төсөв, МУХС-гийн хөрөнгөөр 2009 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, тоног төхөөрөмжийг худалдан авахдаа тендерийн хуулийн зохих заалтын дагуу үнэлж дүгнээгүй, гүйцэтгэгчийг оновчтой сонгоогүйгээс хэрэгжих боломжгүй гэрээ байгуулсан байлаа. Тухайлбал,

- БОАЖЯ-ны харьяа Усны газраас зарласан Усны эрэл хайгуулын 180.0 сая төгрөгийн багцалсан нээлттэй тендер шалгаруулалтад “Ус амьдрал”, “Мурап” ХХК-уудын тендерийн материал бүрэн бус байхад үнэлгээний хороо нь (дарга Я.Цэдэнбалжир) тендерийн хуулийн 30 дугаар зүйлийн 1-ийн 1¹-ийг зөрчин “Мурап” ХХК-ий туслан гүйцэтгэгч “Гуа Нур” ХХК-ийг шалгаруулсан байна.
- БСШУЯ Баянгол дүүргийн “Монгени” цогцолбор сургуулийн өргөтгөлийн 629,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй барилга угсралтын ажлыг 2009 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр ашиглалтад оруулахаар “МБҮ” ХХК-тай гэрээ байгуулсан боловч хэрэгжээгүй, ажлын гүйцэтгэл 30 хувьтай байгаа нь тус компани өөрийн гэсэн мэргэжлийн үндсэн ажилчидгүй, техник хэрэгсэлгүй, захиалагчийн зүгээс тавих хяналт сул байгаатай холбоотой байна. Уг барилгын гүйцэтгэгчид санхүүжилтийн 50 хувийг олгосон ба хөндлөнгийн экспертиз оруулахаар шийдвэрлэсэн тул БУА зогсонги байдалд байна.
- МХХТГ сумдад хөдөлгөөнт холбооны үйлчилгээ хүргэхтэй холбогдуулан нарны үүсгүүр, цэнэг хураагуур суурилуулах 1651,8 сая төгрөгийн ажлыг гүйцэтгэхдээ Сангийн сайдын зөвшөөрлийн дагуу хязгаарлагдмал тендер шалгаруулалтын

¹ ТБОНӨХБАУАТХуулийн 30.³ д “Шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэ захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн тохиолдолд” захиалагч тендерээс татгалзана.
ТБОНӨХБАУАТХ-ийн 41.²2 жилээс дээш хугацаанд хэрэгжих гэрээний явцад хэрэглээний үнийн индекс өөрчлөгдсөнөөс бусад тохиолдолд гэрээний үнийг нэмэгдүүлэн өөрчлөхийг хориглоно.

аргыг ашигласан боловч шаардлага хангасан нэг ч тендерийн материал ирээгүйгээс тендерийг цуцалсан байна. ТБОНӨХБАҮХАТХуулийн 30-д заасны дагуу шууд гэрээний аргыг сонгохдоо хязгаарлагдмал тендер шалгаруулалтад оролцсон “Энерко” ХХК-тай гэрээ байгуулжээ.

1.13 Улсын төсөв, МУХС-гийн хөрөнгөөр санхүүжигдэж байгаа төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ зарим яам, байгууллагууд батлагдсан төсөвт өртгөөс хэтрүүлж гэрээ байгуулан худалдан авах ажиллагааны үр ашигтай, хэмнэлттэй байх боломжийг алдагдуулжээ.

1.14 БСШУ-ны салбарт 2007-2009 онд орон нутагт эрх шилжүүлсэн зарим төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхдээ аймаг, нийслэлийн засаг дарга нар батлагдсан төсөвт өртгөөр бус тендерт шалгарсан үнээр гэрээ байгуулж ТБОНӨХБАҮХАТХуулийн 41.1², 30.1³ дахь заалтыг зөрчиж байна. Тухайлбал:

- *Дорноговь аймгийн Сайншанд сумын 230.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 960 суудалтай сургуулийн барилга угсралтын ажилд “Дархан трейд” ХХК шалгарч, шугам сүлжээний техникийн нөхцөл, гадна холболтын зураг байхгүй, дулаан, цахилгаан болон бусад эх үүсвэрийн хөрөнгийн асуудлыг шийдвэрлээгүйгээс батлагдсан төсвийг 1767,0 сая төгрөгөөр хэтрүүлж, 1997.0 сая төгрөгөөр гэрээ байгуулсан;*
- *Говьсүмбэр аймгийн Сүмбэр сумын 223.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 100 ортой хүүхдийн цэцэрлэг-яслийн цогцолборыг барих тендерт “Мөнхийн үргэлжлэл” ХК шалгарсан боловч анх батлагдсан газрыг аймгийн удирдлагаас өөрчилж, өөр газар шилжүүлснээс төсөвт өртөг 135.0 сая төгрөгөөр нэмэгдсэн;*
- *Хөвсгөл аймгийн Рашаант сумын 314.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй цэцэрлэгийн барилгын анхны өртөг 180.8 сая төгрөгөөр өссөн.*

Хөрөнгө оруулалтын гэрээнд зарим гол нөхцлийг тодорхой заахгүй байна

1.15 Зарим захиалагч байгууллага улсын төсөв, МУХС-гийн төсвийн хөрөнгөөр гүйцэтгэж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гэрээг байгуулахдаа зохих хууль тогтоомж, заавар журмыг баримтлаагүй байна. Тухайлбал:

- *МОНЦАМЭ агентлаг хэвлэлийн тоног төхөөрөмж худалдаж авах гэрээнд тусгай нөхцөл (марк, төрөл, хүчин чадал гэх мэт), нийлүүлэх хугацааг тодорхой тусгалгүй орхигдуулж тендерийн жишиг баримтад заасан гэрээний загварын дагуу боловсруулаагүй;*
- *Цөмийн энергийн газар бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай 5 гэрээ, МХХТГ 3 гэрээнд тусгай нөхцлийг нарийвчлан тусгаагүй;*
- *Улаанбаатар хотын Баянзүрх дүүргийн 5 дугаар хорооны нутаг дэвсгэрт баригдах 320,0 сая (2007 онд 70.0 сая, 2008 онд 225,0 сая, 2009 онд 25,0 сая) төгрөгийн төсөвт өртөгтэй 100 ортой хүүхдийн цэцэрлэгийн барилгын ажлын гүйцэтгэгч “СБМ” ХХК-тай захиалагч НБХБТГ 2007 оны 12 дугаар сарын 27-нд хийсэн гэрээнд ажлыг эхлэх, дуусгах хугацааг заагаагүйгээс нэмэлт гэрээгээр 2009 оны 12 дугаар сарын 12-нд ашиглалтад оруулахаар сунгасан*

² ТБОНӨХБАҮХАТХ-ийн 41 дүгээр зүйл. Худалдан авах гэрээнд нэмэлт өөрчлөлт хийхийг хориглоно. Үүнд: 41.1.2-захиалагч урьдчилан харах боломжгүй нөхцөл байдал үүссэний улмаас гэрээнд зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлт хийхээс бусад тохиолдолд тендерийн агуулгатай холбоотой гэрээний нөхцөлүүдийг өөрчлөх;

³ ТБОНӨХБАҮХАТХ-ийн 30 дугаар зүйл. Бүх тендерээс тагталзана: Үүнд: 30.1.3- шаардлагад нийцсэн бүх тендерийн үнэ захиалагчийн тооцсон төсөвт өртгөөс 5-аас дээш хувиар хэтэрсэн;

боловч ажлын гүйцэтгэл 80 хувьтай байхад санжүүжилтийг бүрэн олгосон байна.

1.16 ТБОНӨХБАҮХАТХ-д зөвхөн захиалагчийн эрх үүргийг заасан боловч гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагын талаар тодорхой заагаагүйгээс хариуцлага тооцох боломжгүй байна.

1.17 Зураг төсөвгүй объектыг төлөвлөгөөнд тусгаснаас зураг төсөл зохиох болон экспертизийн дүгнэлт гаргах зэрэг үе шатны ажлууд удааширч, зарим объектын гүйцэтгэгч шалгаруулах тендер зарлах хугацаа хойшилж, улмаар ашиглалтад орох хугацаанд нөлөөлж байна. Үүнд:

- “Хайлааст” чиглэлийн 1.1 км, “Баруун салаа” чиглэлийн 4.1 км, “Орбит-Тахилт” чиглэлийн 7.1 км автозамын зураг төслийг “Ти Би И” ХХК хугацаанд нь хүлээлгэж өгөөгүйгээс дээрх замын барилгын ажлын тендер зарлах хугацаа хойшилсон;
- “МСРС gr” ХХК-ий хийж гүйцэтгэсэн Хөвсгөл аймгийн Түнэл сумын Эгийн голын 160 у/м төмөр бетон гүүрийн зураг төсөв алдаатай, геологийн дүгнэлт газар дээрээ зөрүүтэй байсан;
- Дорноговь аймгийн хөгжимт драмын “Саран хөхөө” театрын 988.2 сая төгрөгийн өртөгтэй барилгын ажлыг ТБОНӨХБАҮХАТХ-ийн 45.2.3⁴-т заасан заалтыг зөрчин орон нутагт тендер зарлаж “РЭМУГС” ХХК шалгарч, гэрээ ёсоор 2009 оны 10 дугаар сарын 1-нд ашиглалтад оруулахаар байсан боловч хугацааг 2010 оны 6 дугаар сарын 1 хүртэл сунгажээ. Энэ нь тус барилгын зураг төсвийн гүйцэтгэгч “ТГТ” ХХК-ийн зураг төслийг экспертизээр хянуулж, баталгаажуулаагүй байсантай холбоотой байна.

1.18 Улсын төсөв, МУХС-гийн хөрөнгөөр 2009 онд хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн тендерт шалгарсан нийт 453 аж ахуйн нэгжээс 95 аж ахуйн нэгж нэгээс дээш тендерт шалгарсан байна. (Хавсралт №2)

№	Гүйцэтгэгч	Төсөл арга хэмжээ	Тоо	Мөнгөний дүн (сая төгрөгөөр)
1	“Хурдны зам” ХХК	Зам, гүүр	5	7190.6
2	“Илч хангай” ХХК	ЦДАШ, дэд станц	9	5462.7
3	“Одкон холдинг” ХХК	Дулааны шугам сүлжээ, ЦДАШ	5	4296.1
4	“ЭХБУТ” ХХК	Дэд станц, ЦДАШ	6	3397.0
5	“MCS” электроникс ХХК	Электрон тоног төхөөрөмж	11	1191.9
6	“Саммит” ХХК	Электрон тоног төхөөрөмж	7	391.9
7	“Мигма” электроникс” ХХК	Электрон тоног төхөөрөмж	5	222.1

1.19 Судалгаанаас үзэхэд тендерт оролцсон аж ахуйн нэгжүүдээс дээрх 7 компанид 2009 онд хийсэн хөрөнгө оруулалтын санжүүжилтийн 10.3 хувь оногдож байгаа бөгөөд хамгийн их санжүүжилт авсан нь “Хурдны зам” ХХК, хамгийн олон тендерт шалгарсан нь “MCS” ХХК байна.

1.20 Дээрх компаниудаас “Хурдны зам” ХХК зам, гүүрийн 5 тендерт шалгарсан ч 2 тендерийн ажлыг гэрээний хугацаанд гүйцэтгээгүй бөгөөд бусад байгууллагууд хугацаандаа хийжээ.

⁴ ТБОНӨХБАҮХАТХ-ийн 45 дугаар зүйл. Захиалагч худалдан авах ажиллагааг зохион байгуулах гэсэн заалтын 45.2.3-т 45.2.2-т заасан агентлаг, байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар нь 100-200 сая хүртэл төгрөгийн өртөг бүхий бараа, үйлчилгээ, 150-500 сая хүртэл төгрөгийн өртөг бүхий ажлын хувьд

БҮЛЭГ 2

АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХУУРАМЧААР ГАРГАЖ САНХҮҮЖИЛТ АВАХ ЗӨРЧИЛ АРИЛАХГҮЙ БАЙНА

Гүйцэтгэл дутуу байхад санхүүжилтийг бүрэн олгожээ

2.1 Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хууль болон МУХС-гийн төсвийн тухай хуулиар санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид улсын төсвөөс 213714.1 сая, МУХС-гийн төсвөөс 148142.3 сая, нийт 361856.4 сая төгрөг зарцуулж, улсын төсвөөс 28038.1 сая, МУХС-гийн төсвийн хөрөнгөөс 18492.0 сая, нийт 46530.8 сая төгрөг ашиглагдаагүй байна.

2.2 Засгийн газрын 2009 оны 72 дугаар тогтоолоор баталсан “Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм”-ийн 2.2-т “Улсын комисс нь техникийн комиссын акт, дүгнэлтийг үндэслэн шинээр болон өргөтгөж барьсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргана” гэж заасныг зарим төсвийн ерөнхийлөн захирагч мөрдөж ажиллаагүй байна.

2.3 Гүйцэтгэгчид гэрээнд тусгагдсан ажлыг бүрэн хийгээгүй байхад улсын комисс хүлээж авснаас санхүүжилтийг олгосон зөрчил гарсан байна. Тухайлбал:

- ГЕГ “Замын-Үүд” боомтод чингэлээ, ачааны автомашин шалгах рентген төхөөрөмж бүхий цогцолборын дэд бүтцийн ажлыг гүйцэтгүүлэхээр 5 аж ахуйн нэгжтэй 386.0 сая, Ховдын Ярант, Баян-Өлгийн Цагааннуур, Өмнөговийн Гашуунсухайт, Говь-Алтайн Бургастайн боомтуудын цэвэр усны хангамжид ус цэнгээжүүлэх, зөөлрүүлэгч төхөөрөмж нийлүүлэх, угсрах, суурилуулах ажилд 85.2 сая, бүгд 471.2 сая төгрөгийн санхүүжилтийг авахын тулд хийгдээгүй ажлыг хийснээр гүйцэтгэл гаргаж, СЭЗХ-ийн дарга М.Өлзийбат, ХОАҮГ-ын дарга Х.Норванчиг, хяналтын инженер О.Ашигай, О.Цогт-Очир нар хянаж, ГЕГ-ын дарга баталгаажуулсан;
- Нийслэлд 2009 онд хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зарцуулагдаагүй 6274.0 сая төгрөгийн үлдэгдлийг хөрөнгө оруулалтын барьцааны дансанд байршуулсан;
- Сонгинохайрхан дүүргийн айл өрхүүдийг цахилгаанаар хангах 269.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг “Эрчим инженеринг” ХХК гэрээний дагуу 2009 оны 11 дүгээр сарын 13-нд ашиглалтад өгөөгүй, ажлын болон техникийн комиссын акт, дүгнэлт гараагүй байхад Улсын комиссын дарга И.Мянганбаяр, нарийн бичгийн дарга Б.Лхагважав нарын 9 хүний бүрэлдэхүүнтэй комисс акт үйлдэн, ашиглалтад оруулах тухай 203/2009 дугаар шийдвэрийг 2009 оны 12 дугаар сарын 17-ны өдөр гаргасан.;
- БЗД-ийн 22 дугаар хороо, Зүүн- Алтан-Өлгийд АТП-2183 дэд станц, Шархадны эцэст АТП-1795 дэд станц барьж эрчим хүчээр хангах 133,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг “НЭМҮТ” ХХК 2009 оны 11 дүгээр сарын 20-нд ашиглалтад өгөх ёстой боловч ажлын болон техникийн комиссын акт, дүгнэлт гараагүй байхад 12 дугаар сарын 17-нд 238/2009 дугаар бүхий актыг улсын комиссын дарга НМХГ-ын эрчим хүчний салбар хариуцсан улсын ахлах байцаагч Н.Насанжаргал, нарийн бичгийн дарга НБХБТГ-ын Барилга захиалагчийн хэлтсийн хяналтын инженер Г.Оюунболд, гишүүд нь болох НМХГ-ын улсын ахлах байцаагч Д.Дуламрагчаа, улсын байцаагч Д.Жамсран, н.Энхчимэг, НОБГ-ын Баянзүрх дүүрэг хариуцсан байцаагч н.Цэрэндорж, ашиглагч байгууллага УБЦТС ХК-ийн хяналтын албаны инженер Б.Цэрэнням, зургийн инженер Б.Эрдэнэбат, гүйцэтгэгч байгууллага “Нэмүт” ХХК-ийн захирал Ц.Эрдэнэдаваа нар гарын үсэг зурж тамга, тэмдэг дарж

баталгаажуулсан;

- Улаанбаатар хотын “Чингис хаан” Олон улсын нисэх буудлын онгоц хөөрч, буух хатуу хучилттай зурвасын хүчитгэлийн ажил, гэрлэн тэмдэгт хийж гүйцэтгэх тендерт шалгарсан “Хурдны зам” ХХК тайлант онд гэрээнд тусгагдсан ажлын 60 хувийг хийсэн байхад санхүүжилт бүрэн олгогдсон;
- Завхан аймгийн Нисэх онгоцны буудлын хөөрч буух, хатуу хучилттай зурвас, үерийн далан барих ажлын гүйцэтгэгч “Хурдны зам” ХХК 174.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэсэн атал 1176.0 сая төгрөгийн илүү санхүүжилт авсан;
- ХХААХҮЯ услалтын систем шинээр барих, сэргээн засварлах ажлыг улсын комиссын актыг үндэслэн гүйцэтгэснээр тайлагнасан байна. Гэвч зарим ажлууд бүрэн хийгдээгүй бөгөөд Төв аймгийн Батсүмбэр сумын ЗДТГ, Хэнтий аймгийн Бор-Өндөр тосгоны захирагчийн алба, “Гуру” “Зүүн хөвч”, “ІSTA”, “Өгөөмөр мандал” ХХК-уудын ажлын гүйцэтгэл 20-85.0 орчим хувьтай;
- Завхан аймгийн ЗДТГ-ын конторын барилгын дуусгалд 279.0 сая төгрөг батлагдсаныг бүрэн санхүүжүүлсэн боловч улсын комиссын акт гараагүй;
- “Меговатт” ХХК “Дарханы дулааны цахилгаан станц” ХК-иас Дархан хот хүртэлх дулааны магистраль шугамын барилга угсралтын 6500,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлаас 214,6 сая төгрөгийн ажлыг гүйцэтгээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон;
- НБХБТГ-ын дарга Н.Нацагдорж “Элком” ХХК-тай Чингэлтэй дүүргийн 12 дугаар хорооны 60 ортой цэцэрлэгийн барилгыг, “Материал трейд” ХХК-тай Баянзүрх дүүргийн 6 дугаар хорооны 100 ортой цэцэрлэгийн барилгыг барих гэрээ байгуулж хэрэгжүүлээгүйгээс хугацааг жилээр сунгаж ашиглалтад хүлээлгэж өгөөгүй байхад санхүүжилтийг 100 хувь олгосон;
- “Замын Үүд” эдийн засгийн чөлөөт бүсийн мэргэжлийн албадын нэгдсэн байрны барилгын гүйцэтгэгч “Проспект Интернейшнл” ХХК-д гүйцэтгэл 90 хувь, “Алтанбулаг” худалдааны чөлөөт бүсийн 4 багц төсөл, арга хэмжээ 70-90 хувийн гүйцэтгэлтэй, хугацаандаа хэрэгжээгүй байхад санхүүжилтийг бүрэн олгосон байна.

2.4 Ийнхүү гэрээнд заагдсан ажлыг хийж дуусаагүй байхад улсын комиссын гишүүд хүлээн авч акт үйлдсэн нь гүйцэтгэгчид санхүүжилтийг бүрэн олгох, тухайн ажил хугацаандаа хийгдэхгүй, чанарын шаардлага хангагдахгүй орхигдох, улмаар нэмэлт төсөв хөрөнгө шаардах боломжийг бүрдүүлж байна.

2.5 Орон нутагт хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээг хүлээн авах улсын комиссын гишүүдийг тухайн аймгийн Засаг даргын шийдвэрээр баталдаг бөгөөд захиалагч байгууллагын төлөөллийг оруулах дүрмийг мөрдөж ажиллахгүй байгааг анхаарах нь зүйтэй юм.

2.6 Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлийг гүйцэтгэгчтэй хуйвалдан хуурамчаар гаргаж, хүлээн авах акт гаргаж байгаа улсын комиссын гишүүдэд хариуцлага тооцох шаардлагатай байна.

2.7 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл оны эцсээр гардагаас санхүүжилтийн 39.7 хувь 11-12 дугаар сард, үүний дотор 30 гаруй хувь 12 дугаар сард олгогдсон байна.

2.8 Цаашид хөрөнгө оруулалтын зарцуулагдаагүй үлдэгдлийг төрийн санд тусгай харилцах данс нээн түр байршуулж, зарцуулах, эсхүл санхүүгийн жилийг оновчтой болгох, хөрөнгө оруулалтын хугацааг ялгавартай тогтоох асуудлыг судалж үзэх нь зүйтэй юм.

Хөрөнгө оруулалтын ажлыг гэрээнд заасан хугацаанд хэрэгжүүлээгүй байна

2.9 ТБОНӨХБАУХАТХуулийн дагуу тендерт шалгарч гэрээ байгуулсан зарим гүйцэтгэгч компаниуд гэрээний үүргээ биелүүлээгүй байна. Тухайлбал:

- “Пума” ХХК СЯ-ны болон УТЕГ-ын конторын барилгыг хугацаанд нь ашиглалтад оруулаагүй;
- ЭБЭХ-ний салбарт 2009 оны жилийн эцсийн тайлан тэнцлээр улсын төсвөөр хэрэгжсэн 74.2 тэрбум төгрөгийн 50 барилга угсралтын ажил хугацаандаа ашиглалтад ороогүй, дуусаагүй барилгын үлдэгдэлтэй байгаагаас 2010 онд шилжих барилга 5 байна. Үүнд: 2007 онд эхэлсэн 49.2 тэрбум төгрөгийн 29, 2008 онд эхэлсэн 1.3 тэрбум төгрөгийн 1, 2009 онд эхэлсэн 17.1 тэрбум төгрөгийн 11 төсөл, арга хэмжээ дуусаагүй, ашиглалтад хүлээн аваагүй;
- 2009 онд ашиглалтад орох гэрээтэй Эмээлтийн 35/10 кВ-ын дэд станц, 4 км цахилгаан дамжуулах шугам, Хайлаастын гэр хорооллын дэд станц 110/35/10 кВ, 2х16,0 мВА, ил хуваарилах байгууламж 4-д 220/110/35 кВ-ын 125 мВА чадалтай автотрансформатор суурилуулах, “Хайлааст” дэд станцаас Яргайт дэд станц хүртэл 35 кВ-ын 2 хэлхээт 9 км цахилгаан дамжуулах шугам, умард дэд станцын трансформатор хаалттай дэд хуваарилах байгууламжийн өргөтгөл, шинэчлэлтийн ажил дуусаагүй;
- “Хотын зам” ХХК-ийн барьж байгаа 3.9 тэрбум төгрөгийн Их тэнгэрийн гүүр барих гэрээний хугацаа 2009 оны 11 дүгээр сарын 1-нд дууссан боловч 996.0 сая төгрөгийн ажил хийгдээгүй;
- ЭМ-ийн салбарын хэмжээнд 6.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 барилга байгууламж гэрээт хугацаанд дуусаагүй;
- БОАЖЯ-нд 2,0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй үүлэнд нөлөөлөх явуулын радарын станцыг “Спейшл корпораци” ХХК 2010 оны 2 дугаар сарын 24-нд нийлүүлэхээр гэрээ байгуулсан боловч нийлүүлээгүй;
- 2006 онд эхэлсэн Дундговь аймгийн галын депо, 6 айлын орон сууцны барилгыг гүйцэтгэгч “Өнөмөнх Монгол” ХХК анхны гэрээ ёсоор 2007 оны 10 дугаар сарын 25-ны дотор, нэмэлт гэрээгээр 2007 оны 12 сарын 15-ны дотор, 3 дахь нэмэлт гэрээ ёсоор 2009 оны 8 дугаар сарын 31-ний дотор ашиглалтад өгөх ёстой ч дуусаагүй;
- БСШУ-ны салбарын 2007-2009 онд хэрэгжих 21.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 32 барилгын ажлын гүйцэтгэл 30-90 хувьтай байгаа нь үнийн өсөлтөөс нэмэлт хөрөнгө шаардагдсан 9, дараа онд шилжиж хэрэгжих 17, орон нутагт эрх шилжүүлэн хянаж санхүүжүүлсэн 3, тус яамнаас санхүүжүүлсэн 3 төсөл арга хэмжээтэй холбоотой байна.

2.10 Захиалагчийн зүгээс барилга угсралтын ажлын гүйцэтгэлийн үе шатны ажлуудад тавих хяналт хангалтгүй, тендерийг оройтож зарласан, эрх шилжүүлсэн ажилд орон нутгийн засаг захиргаа хариуцлагагүй хандсан, гүйцэтгэл дутуу байхад санхүүжилтийг олгосон, гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгчид хариуцлага тооцдоггүйгээс барилга байгууламж хугацаандаа ашиглалтад орохгүй, санхүүжилт оройтох, тоног төхөөрөмж нийлүүлэгдэхгүй удаашрах, журам заавар зөрчих дутагдал бүрэн арилахгүй байна. Тухайлбал,

- МУХС-гийн хөрөнгө оруулалтаар Могойн гол дээр цахилгааны эх үүсвэр барих ТЭЗҮ хийлгэх, Тэлмэн-Могойн голын ЦДАШ, дэд станц барихад 3,8 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр баталжээ. Хөвсгөлийн Могойн голд цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх станц баригдаагүй байхад Тэлмэн-Могойн голын ЦДАШ барихаар шийдвэрлэж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан байна. Энэхүү ажлыг гүйцэтгүүлэхээр “ЭХБУТ” ХХК-тай 2009 оны 12 дугаар сарын 28-ны өдөр ЭХБУ 09/022 тоот гэрээг байгуулан тус компанид 2009 оны 12 дугаар сарын 29-ний өдөр 2,5 тэрбум төгрөг буюу нийт төсөвт өртгийн 71,4 хувийг шилжүүлсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2008 оны 58 дугаар тушаалаар баталсан журам¹-ын 3.5¹ дахь заалтыг зөрчсөн байна.

Хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэлд тавих явцын хяналт хангалтгүй байна

2.11 Улсын төсөв, МУХС-гийн хөрөнгөөр санхүүжигдэж байгаа барилга байгууламжид явцын болон чанарын хяналт дутагдаж байна. Тухайлбал:

- Хэнтий аймгийн “Тэмүүжин” сургуулийн спорт заалны барилгын хана өрөгдөөд дуусч байхад чанарын сертификатгүй тоосгоор өрлөг хийсэн нь илэрч ажлыг зогсоосон;
- Хэнтий аймгийн Батширээт сумын цэцэрлэгийн барилга угсралтын ажлын тендерийг орон нутаг зохион байгуулсан ба барилгын зургийг “Батпроект” ХХК гүйцэтгэхдээ орон нутгаас өгсөн техникийн нөхцлийн дагуу хийгээгүй;
- Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 212 дугаар тогтоолын дагуу НХХЯ-наас ахмад дайчдад орон сууц олгох явцад СИ 13031016 регистрийн дугаартай иргэн Шагдар овогтой Гүнчиншарав 2006 оны 8 дугаар сарын 22-ны өдөр нас барсан атал 2008 оны 8 дугаар сарын 28-ны өдөр нас барснаар Налайхын иргэний бүртгэлийн алба бүртгэж, хуурамч баримт бүрдүүлэн охин Г.Очирхуяг СХД-ийн 6 дугаар хороонд “МВС” ХХК-ий 63 дугаар байрны 19 тоот орон сууц авсан байна. Энэ нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Дайнд оролцсон ахмад настангуудын талаар авах зарим арга хэмжээний тухай” 2008 оны 170 дугаар зарлигийн дагуу НХХС, БХС, ЗТБХБС-ын 2009 оны 108/242/193 дугаар тушаалаар баталсан “Дайнд оролцсон ахмад дайчинд орон сууц олгох журам”-ын 1.4.1² дахь заалтыг зөрчжээ.

2.12 2009 онд ЗТБХБ-ын салбарт ашиглалтад оруулаагүй ажлын 12 гэрээний 306.9 км авто зам, 6 гэрээний 1304.8 метр урт төмөр бетон, 1 гэрээний 127.1 уртааш метр модон гүүрийн барилгын ажлуудын талаар гэрээ дүгнэж, сайдын зөвлөлөөр хэлэлцэн шийдвэр гаргасан ч явцын хяналт, гэрээний үүргийн биелэлт хангалтгүй байна. Үүнд:

- “Эрдэнэт суварга” ХХК, “ЗМЗ” ХХК, “Бэрх зараа” ХХК-уудын Дашинчилэн-Орхоны гүүр чиглэлийн 10-40 км, “Хурдны зам” ХХК-ий Цэцэрлэг-Цэцүүх чиглэлийн 37.5 км, Хануйн гүүр-Халзанбүргэдэй чиглэлийн 5.2 км, “Саруул жим” ХХК-ий Архангайн Хөшөөт цайдам-Өгийнуурын 10 км, “Композит Асто” ХХК-ий Хөвсгөл аймгийн 1.1 км, “Хотгор” ХХК-ий Улаангом-Тээлийн гүүрийн чиглэлийн 15 км, “Очир төв” ХХК-ий УБ-Лүнгийн 106.2 км, “Читай” ХХК-ий Булган-Үенчийн 40 км, “Хөвсгөл зам” ХХК-ий Хөвсгөл аймгийн 1.9 км, “Архангай авто зам” ХХК-ий Хархорин-Цэцэрлэгийн 10 км авто зам;
- “Гангүүр” ХХК-ий Туул голын Горхийн чиглэл дэхь 211 у/м, “Мөнх жим” ХХК-ий Увс аймгийн Тэс сумын Нарийний голын 325 у/м, “Хотын зам” ХХК-ий Их тэнгэрийн 258

¹ 3.5-т¹ “... захиалагч, гүйцэтгэгчийн хооронд зохих журмын дагуу байгуулсан гэрээ, захиалагчийн санхүүжилт хүссэн албан тоот зэргийг үндэслэн эхний удаа тухайн барилга, их засварын ажлын гэрээний үнийн... 30 хүртлэх хувийн урьдчилгаа олгож болно.”

² “1939 оны Халх голын байлдаан, 1945 оны чөлөөлөх дайн, улсын баруун хил дээр 1940-1048 онд болсон зэвсэгт тулгаралтад биечлэн оролцсон, Монгол Улсын харъяат, одоо амьд сэрүүн байгаа ахмад дайчин”-д орон сууц олгохоор заасан

у/м, “Хөвсгөл зам” ХХК-ий Эгийн голын 160 у/м, “Жол” ХХК-ий Ховд голын 181.8 у/м, “Завхан АЗЗА” ХХК-ий Завхан аймгийн Идэрийн голын 169.08 у/м төмөр бетон гүүр;

- “Мон Рос-Алтай” ХХК-ий Ховд голын 127.09 у/м модон гүүрийг гэрээнд заасан хугацаанаас 60- 180 хоног хэтрүүлсэн байна.
- Арабын эдийн засгийн Кувейтын сангийн зээлийн хөрөнгө болон Монгол Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжигдэж байгаа Булган-Уньтын 74 км замыг гүйцэтгэж байгаа “Насны зам” ХХК-ий гэрээг 2 удаа сунгасан боловч, захиалагч, гүйцэтгэгчийн талаас гэрээний үүргийн биелэлтийг дүгнэж, хариуцлага тооцоогүй байна.

2.13 БСШУЯ-наас орон нутагт хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний техник хяналтын зардалд зориулан аймаг, нийслэлийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт 66.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон боловч хяналтын бодит үр дүн хангалтгүй байна.

2.14 Сангийн яамны конторын барилгын ажлын гүйцэтгэл, чанарт хяналт тавих үүрэг бүхий алба 2008-2009 онд барилга захиалагчийн хяналтын зардалд 57.7 сая төгрөгийн санхүүжилт авсан боловч барилга угсралтын ажилд тавих хяналт хангалтгүйгээс барилга угсралтын ажил хугацаандаа гүйцэтгэгдээгүй, ашиглалтад ороогүй, барилгын ажлын нэмэгдсэн төсөвт өртгийг экспертизээр хянан баталгаажуулаагүй байна.

2.15 Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийн хяналтыг сайжруулах, арга хэмжээ авч ажиллах талаар 2009 онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар зохиосон ажлын үр дүн төдийлэн харагдахгүй байгаа бөгөөд цаашид хөрөнгө оруулалтын явцын хяналтад захиалагчаас гадна ашиглагч болон тухайн орон нутгийн засаг захиргааны нэгжийн төлөөллийг оролцуулж байх нь зүйтэй юм.

Хөрөнгө оруулалтын зориулалтыг өөрчилжээ

2.16 Улсын төсөв, МУХС-гийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын зориулалтыг өөрчилсөн зөрчил илэрлээ.Тухайлбал:

- ЗГХЭГ-ын даргын багцад Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэдэх хэвлэлийн төв телестуди байгуулахаар батлагдсан 142.0 сая төгрөгөөс 94.7 сая төгрөгийн зориулалтыг өөрчилж “Соната 6” автомашин 3-ыг худалдан авсан;
- Говьсүмбэр аймагт 2009 оны боловсролын салбарт улсын төсвийн хөрөнгө оруулалтаар их засварын зардалд хуваарилсан 100.0 сая төгрөгөөс 9.0 сая төгрөгөөр аймгийн боловсролын газарт 2 өрөө орон сууц, 4.0 сая төгрөгөөр тавилга хэрэгсэл худалдан авч, мөн УБ хотын “Залуу сэтгүүлчдийг дэмжих холбоо”-той телевизийн студи байгуулах гэрээ хийж тус холбооны дансанд 11,9 сая төгрөгийг шилжүүлсэн боловч шалгалтын үед хэрэгжээгүй, данс бүртгэлд тусгаагүй байв. Энэ нь ТБУСТХ-ийн 8.1.4, МУ-ын нэгдсэн төсвийн тухай хуулийн 6.1.3 дахь заалт, Сангийн сайдын 2008 оны 58 дугаар тушаалыг зөрчсөн;
- Төв аймгийн Лүн суманд Соёл амралтын хүрээлэн байгуулахад 500.0 сая төгрөг батлагдсан боловч орон нутгийн зүгээс зориулалтыг өөрчлүүлэх санал гаргаснаас хэрэгжилт зогсож, 150.0 сая төгрөгөөр хашаа барьсан.

2.17 Ийнхүү Сангийн сайдын 2008 оны 58 дугаар тушаалаар батлагдсан журмын 1.5³-дахь заалтыг зөрчиж, төлөвлөгөөнд тусгаагүй, шаардлага багатай хөрөнгө оруулалт хийж, зориулалтыг өөрчилж байгааг анхаарах нь зүйтэй байна.

Үнийн өсөлтөөр нэмэгдсэн зардлыг шийдэхдээ салбар, объектуудад харилцан адилгүй хандсан байна

2.18 МУХС-гийн 2009 оны төсвийн тухай хуульд оруулсан өөрчлөлтөөр авто зам, барилга, эрчим хүчний салбарт 2008 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтөөр нэмэгдсэн зардлын хэмжээг 12866.8 сая төгрөгөөр баталсан байна.

2.19 2008 оны улсын төсвийн болон МУХС-ийн хөрөнгөөр хийгдсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явцыг хянан үзэж, нэмэгдэл зардал гарсан гүйцэтгэгчид нэмэлт гэрээ байгуулж олгосон хөрөнгийг салбараар харуулбал,

(сая төгрөгөөр)

Төсөл, арга хэмжээний нэр хүч чадал, байршил	Хамарсан объектын тоо	Гэрээний дүн	Үнийн зөрүү		
			Яам, агентлагаас ирүүлсэн санал	УИХ-аас баталсан дүн	Өсөлтийн хувь
БСШУС	42	16,615.2	2,230.7	1,115.3	30.7
ХЗДХС	3	10,809.1	1,295.7	647.9	22.1
ШЕЗ	2	1,019.9	256.9	128.4	40.2
БХС	4	6,217.3	1,267.2	633.6	29
СС	5	9,990.3	2,489.2	1,244.6	79.9
ЭБЭХС	11	25,066.0	1,883.3	941.6	9.2
НЗД	2	14,850.0	2,953.8	1,476.9	27.1
ЗТБХБС	41	220,167.4	11,451.9	5,726.1	28
Авто зам	22	131,235.2	7,007.0	3,503.5	31.6
Гүүр	8	15,415.9	524.1	262.1	32.9
ИНЕГ	6	61,010.1	2,967.1	1,483.6	21.3
ЗТБХБС	5	4,506.2	953.7	476.9	151.4
ТЕГ	1	280.2	46.5	23.3	29.6
ОБЕГ	1	861.0	489.5	244.8	
ЭМС	3	2,163.0	1,368.9	684.5	99.4
НИЙТ ДҮН	115	307,178.4	25,733.6	12,866.8	27.0

2.20 Авто зам, барилга, эрчим хүчний салбарт 2008 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтөөр нэмэгдсэн зардал дунджаар 27.0 хувь байхад зарим гүйцэтгэгчид олгосон үнийн өсөлтийн зардлын хувь харьцангуй өндөр байна. Үүнийг зарим яам, агентлаг, газар, байгууллагын хэмжээнд авч үзвэл:

- 2006 онд хэрэгжсэн Увс аймгийн Улаангом сумын Төрөх эмнэлгийн барилгад 82.2, Тэс сумын Нарийнголын төмөр бетон гүүрт 30.7, Өвөрхангай аймгийн 600 суудалтай спорт цогцолборт 46.1, УГЕГ-ын албан конторын барилгад 82.4, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн конторын барилгад 27.4, Хархорин Хужирт чиглэлийн хатуу хучилттай автозамд 29.5, Улаанбаатар хотын Дамдинсүрэнгийн гудамжны автозамд 30.4, 2007 онд хийгдсэн УТЕГ-ын конторын барилгад 90.1, Сангийн яамны конторын барилгад 86.4, Булган аймгийн 450 суудалтай спорт цогцолборын барилгад 201.5 хувиар тус тус тооцож

³ “Улсын болон орон нутгийн төсөв, МУХС-гийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, барилга байгууламж, их засвар, худалдан авах тоног төхөөрөмжийг хооронд нь шилжүүлэн санхүүжүүлэхийг хориглоно”

үнийн зөрүүг олгосон байна.

2.21 Зарим салбарт тендерт шалгарсан компаниуд барилгыг хугацаанд нь ашиглалтад оруулахгүй, төсөвт өртгийг жилээс жилд өсөн нэмэгдүүлэх байдал харагдаж байна.Тухайлбал:

- Сангийн яамны конторын барилга угсралтын ажлыг “Пума” ХХК 2398.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэйгээр гүйцэтгэхээр тендерт шалгарч 2008 оны 12 дугаар сарын 29-ний дотор ашиглалтад оруулахаар гэрээ байгуулсан ч нэмэлт өөрчлөлт оруулан гэрээний төсөвт өртгийн дүнг 4042.5 сая төгрөгөөр нэмэгдүүлжээ. Мөн УИХ-ын 2009 оны 27 дугаар тогтоолын дагуу материалын үнийн зөрүүд олгосон 391.0 сая төгрөгийг нэмэлт гэрээнд тусгаагүй бөгөөд энэ дүнг оруулснаар 4433.5 сая төгрөгийн төсөвт өртгийн тооцоо гарч байгаа нь анх тендерт ялсан дүнгээс 2034.6 сая төгрөг буюу 84.8 хувиар нэмэгдсэн байна.
- ҮТЕГ-ын конторын барилга угсралтын ажлыг мөн “Пума” ХХК анх 2400.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй гүйцэтгэхээр 2007 оны 8 дугаар сарын 31-нд эхэлж 2008 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр ашиглалтад оруулах гэрээтэй атал 2009 оны 9 дүгээр сарын 1, 2010 оны 4 дүгээр сарын 15-нд ашиглалтад оруулахаар сунгаж, анхны төсөвт өртгийг 1000.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн 3400.0 сая төгрөг болгожээ. Үнийн өсөлтөөр 353.3 сая төгрөгийг нэмж авснаар 3753.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй болсон нь анх тендерт ялсан үнийн дүнгээс 1353.4 сая төгрөг буюу 56.4 хувиар өсчээ.
Дээрх 2 барилгын гүйцэтгэгч “Пума” ХХК тендерт ялахын тулд зарласан үнээс доогуур үнээр оролцож, эрх авсны дараа янз бүрийн шалтгаанаар төсөвт өртгийг нэмэгдүүлсэн, санхүүжилтээ бүрэн авсан боловч барилгын ажлыг хугацаанд нь дуусгаагүй, барилга барих хугацааг сунгасаар байна.
- ГЕГ-ын захиалгатай Сангийн яамны ажиллагсдын 60 айлын орон сууцны барилгыг 2007 онд 1802.0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр “Шинэ барилга” ХХК тендерт шалгарсан бөгөөд нэмэлт санхүүжилт хийгдсээр 2910.5 сая төгрөг буюу анх тендерт ялсан төсөвт өртгөөс 1108.5 сая төгрөг буюу 61.5 хувиар нэмэгдсэн байна.
- ЭБЭХ-ний салбарт хэрэгжиж байгаа 43 төсөл арга хэмжээний үнийн өсөлтийн нэмэгдсэн зардалд 4.8 тэрбум төгрөг шаардлагатай байгаа талаар Сангийн яаманд хүсэлт тавьсан боловч зөвхөн 11 төсөл, арга хэмжээнд 941.6 сая төгрөгийг төсвийн тодотголоор нэмж баталсан байна.
- 2008 онд ОБЕГ-аас “Монжап интернэйшнл” ХХК-тай хийсэн гэрээ ёсоор Дундговь аймгийн Сайнцагаан суман дахь шатахууны агуулахыг Дорноговь аймгийн Айраг суманд шилжүүлэн барихад 859.1 сая төгрөг зарцуулах байтал материалын үнийн өсөлтөөр 244.8 сая төгрөг нэмж олгожээ.

2.22 Худалдан авалтын үйл ажиллагаатай холбоотой зөрчил дутагдлаас гадна 152 объектод хамаарах 30.8 тэрбум төгрөгийн ажлын гүйцэтгэл дутуу байгаа нь нэмэлт төсөв шаардагдсан, чанарын шаардлага хангаагүй, ажиллах хүч, техник хангамж дутагдсан зэрэг шалтгаанаар ажил хийгдээгүйтэй холбоотой байна.

2.23 Зөрчил дутагдлын улмаас хугацаандаа бүрэн хэрэгжих боломжгүй болсон төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалтыг хавсралт №3-т үзүүлэв.

БҮЛЭГ 3

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ БҮРЭН АШИГЛААГҮЙ БАЙНА

Хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг үнэн зөв гаргаагүй байна

3.1 Улсын төсөв, МУХС-гийн хөрөнгөөр 2009 онд санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн тайланг төсвийн ерөнхийлөн захирагчид хугацаанд нь гаргаж хүргүүлсэн боловч зарим байгууллагын хувьд гүйцэтгэлийн тайланг зөрүүтэй тайлагнасан байлаа. Тухайлбал:

- *ЗТБХБЯ-ны хөрөнгө оруулалтын тайланд Улаанбаатар хотын “Чингис хаан” ОУНБ-ын онгоц хөөрч, буух хатуу хучилттай зурвасын хүчитгэлийн ажил, гэрлэн тэмдэгт хийх ажлын талаар гүйцэтгэгч “Хурдны зам” ХХК 2009 онд 1500.0 сая төгрөгийн ажил гүйцэтгэснээр тайлагнасан байна. Гэтэл хийгдээгүй ажлын үлдэгдэл 549.2 сая төгрөг арилжааны банкны дансанд байсныг 2010 оны 1 дүгээр сарын 19-нд Төв төрийн сангийн барьцааны дансанд байршуулжээ.*
- *БСШУЯ-наас Төв, Увс, Ховд аймгийн 3 сургууль, нэг цэцэрлэгт олгосон 25.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг бүртгэлд тусгаагүй орхигдуулсныг аудитын явцад орлогод авахуулж, бүртгэлд тусгуулав.*
- *Нийслэлийн 2 дугаар амаржих газарт 150.0 сая төгрөгийн их засварын хөрөнгийг барилга байгууламжийн өртөгт нэмж тусгаагүй байна.*

Төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэсэн хөрөнгийн ашиглалт хангалтгүй байна

3.2 Улсын төсөв, МУХС-гийн хөрөнгөөр бэлтгэсэн зарим хөрөнгө ашиглалтгүй байна. Тухайлбал:

- *Тайширын усан цахилгаан станц ашиглалтад ороогүйгээс 34.9 тэрбум төгрөгийн төсөвт өртгөөр баригдсан Говь-Алтай, Завхан аймгийн нийт 24 сумын 1600 гаруй км ЦДАШ 2007 оноос хойш ашиглалтгүй байна.*
- *ИНЕГ төсвийн хөрөнгө оруулалтаар 2008-2009 онд 18.9 тэрбум төгрөгийн өртөг бүхий 3 ширхэг бодит ажиглалтын систем буюу радиолокаторыг хүлээн авч байрлуулсан ч мэдээллийн автоматжуулалтын нэгдсэн системийг одоо хүртэл хүлээж аваагүйгээс дээрх радиолокатор ашиглалтгүй, ямар үр өгөөж өгч байгаа нь тодорхойгүй байна.*

3.3 Төсвийн хөрөнгөөр бэлтгэгдсэн хөрөнгийн эх үүсвэрийн тодорхой хувийг эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр бусдад олгох, үнэ төлбөргүй өгөх, үр ашиггүй үрэлгэн зарцуулах явдал арилахгүй байна. Тухайлбал:

- *2009 онд МУХС-гийн хөрөнгөөр ХХААХҮЯ услалтын систем шинээр барих, сэргээн засварлах 27 аж ахуйн нэгж, 19 иргэнд 3547.2 сая төгрөгийн буцалтгүй дэмжлэг олгожээ.*
- *Гаальчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх зориулалтаар 2910.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй баригдсан 60 айлын орон сууцны 47-г Сангийн яамны албан хаагч, 13-ыг ГЕГ-ын ажиллагсадад хуваарилжээ. Аудит хийх үед өмнө нь байр авсан зарим ажилтнууд 1,5-4,5 сая төгрөг тушаасан дүнтэй байлаа.*

3.4 Орон сууцны үнийн тодорхой хувийг эзэмшигчдээр хариуцуулж улсын төсвөөс гаргасан зардлын боломжийн хэсгийг нөхөх, төрийн бусад салбарын ажиллагсадтай ижил нөхцлөөр хандах нь зүйтэй юм.

3.5 ЭМ-ийн салбарт сүүлийн 3 жилд 43854.0 сая төгрөгийн барилга байгууламж, их засварын ажил хийгдсэнээс төрөх, эх нялхсын эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр 2459.9 сая (барилга байгууламжид 1221.2 сая, их засварт 1238.7 сая) төгрөг буюу дөнгөж 5.6 хувь нь зарцуулагджээ.

3.6 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар бэлтгэж байгаа хөрөнгийн эргэн төлөгдөж байгаа эх үүсвэрийг тухайн салбарын тусгай дансанд байршуулж эх үүсвэр болгох талаар Засгийн газрын тусгай сангийн тухай хуулинд зааж журамласан боловч сангийн хөрөнгийн ашиглалтын талаар тодорхой тусгаагүй байна. Тухайлбал:

- МУХС-гаас 2009 онд газар тариаланд дэвшилт техник технологи нэвтрүүлж, газар тариалангийн үйлдвэрлэлийг эрчимжүүлэх зорилгоор 15084.7 сая төгрөгөөр худалдан авсан трактор, комбайн, үр тарианы үрлүүр, сийрүүлүүр, хор цацагч, будаа цэвэрлэгч төхөөрөмжийг Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн бүртгэлд тусгаж, аж ахуйн нэгжид зээлээр олгон, эргэн төлөгдөж байгаа эх үүсвэрийг тухайн санд төвлөрүүлж байна.
- Улсын төсөв, МУХС-ийн хөрөнгөөр БНСУ-аас том оврын 400 автобусыг 31.7 тэрбум төгрөгөөр худалдан авч 10 аж ахуйн нэгжид 6 жилийн хугацаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй гэрээ байгуулан олгожээ. Гэрээнд хөрөнгийн эх үүсвэрийг тусгай санд төвлөрүүлж, нийслэлийн нийтийн тээврийн автобусны парк шинэчлэлтэд зориулахаар заасан байна.

УИХ-ын гишүүдийн орон нутагт хэрэгжүүлэхээр санал болгосон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжилтийн 96.0 хувь нь зарцуулагджээ

3.7 Улсын төсөв, МУХС-гийн төсвийн хөрөнгөөр 2009 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн 9.5 хувь буюу 40008.2 сая төгрөг (улсын төсвөөс 35008.2 сая, МУХС-гийн төсвөөс 5000.0 сая)-ийг УИХ-ын гишүүдийн орон нутагт хэрэгжүүлэхээр санал болгосон төсөл, арга хэмжээнд зарцуулахаар баталжээ. Үүнийг төсвийн ерөнхийлөн захирагчийн багцаар харуулбал:

№	Төсвийн ерөнхийлөн захирагчийн нэр	(сая төгрөгөөр)	
		Мөнгөн дүн	
		Улсын төсөв	МУХС
1	Тэргүүн шадар сайдын багц	11498.5	1500.0
2	Шадар сайдын багц	16499.7	1500.0
3	Сангийн сайдын багц		2000.0
4	ЭБЭХС, ЗТБХБС-ын багц	7010.0	
Нийт дүн		35008.2	5000.0

3.8 УИХ-ын гишүүдийн орон нутагт хэрэгжүүлэхээр санал болгосон барилга байгууламж, төсөл, арга хэмжээнд 38385.4 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж, 1623.1 сая төгрөг хэмнэгдсэн байна. Дээрх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн байдлыг хавсралт № 4¹-өөр гаргав.

¹ УИХ-аас ирүүлсэн "Бүс нутгийн хөгжлийг дэмжих гэдэг нэрээр УИХ-ын гишүүдийн оролцоотойгоор төлөвлөж, хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилт, гүйцэтгэлд аудит" хийх гэсэн захиалгын дагуу нэг бүрчлэн гаргав.

3.9 Аудитын явцад хийсэн судалгаанаас үзэхэд нийт хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний 68.0 хувь бүрэн хэрэгжсэн, 26.1 хувь хэрэгжих шатандаа, харин 5.9 хувь нь санхүүжилт оройтсоны улмаас 2010 онд хийгдэхээр хойшлогдсон байна. Тухайлбал:

- Хэнтий аймагт 13 төсөл, арга хэмжээ 2009 онд хэрэгжихээр батлагдсанаас 4 нь гүйцэд хэрэгжээгүй байна. Тухайлбал, Батноров сумын Б.Урангоо эзэнтэй эсгийний үйлдвэрт 16.4 сая төгрөгийг эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх, 23.6 сая төгрөгийг үйлдвэрийн тоног төхөөрөмж худалдаж авахад зориулж эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон боловч авах тоног төхөөрөмжийн сонголт хийж чадаагүй;
- Жаргалтхаан сумын Н.Готов эзэнтэй эсгийний үйлдвэрт 18.9 сая төгрөгийг эргэлтийн хөрөнгө нэмэгдүүлэх зориулалтаар, 21.0 сая төгрөгийг тоног төхөөрөмж худалдан авахад зориулан олгосон боловч үйл ажиллагаа нь жигдрээгүй;
- 2009 онд Ховд аймагт хэрэгжүүлэх 18 төсөл, арга хэмжээний 17 нь тухайн онд, нэг нь 2009-2012 онд хэрэгжихээр тусгагдсан боловч 2009 оны жилийн эцсийн гүйцэтгэлээр 2.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 8 төсөл, арга хэмжээ хугацаандаа бүрэн хэрэгжиж дуусаагүй;
- Нийслэлд хэрэгжүүлэхээр санал болгосон 1572.6 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг хариуцан гүйцэтгэх эрх бүхий байгууллага тайлант хугацаанд бүрэн хэрэгжүүлээгүйгээс санхүүжилт нь нийслэлийн хөрөнгө оруулалтын барьцаа дансанд байршиж байна. Үүнд: Сүхбаатар дүүргийн 17, 18 дугаар хороонд баригдах 500.0 сая төгрөгийн өртөгтэй 2 цэцэрлэг, Баянзүрх дүүргийн 19, 22 дугаар хороонд баригдах 553.0 сая төгрөгийн өртөгтэй 2 цэцэрлэг, Чингэлтэй дүүргийн ахмад настнуудад зориулсан 275.0 сая төгрөгийн өртөгтэй амралт сувиллын газар, гал тогооны тоног төхөөрөмж, өндөр настнуудад үйлчлэх автобусын үнэ 36.4 сая, Баянзүрх дүүргийн 9 дүгээр хороонд баригдах цэцэрлэгийн 104.6 сая, Баянгол дүүрэгт иргэдэд үйлчлэх нээлттэй засаг сүлжээ байгуулахад зарцуулах 103.6 сая төгрөг;
- Өвөрхангай аймагт хэрэгжих цаг агаарыг тодорхойлогч “Явуулын радар” нийлүүлэх 427.0 сая төгрөгт 2009 оны 12-14 нд тендер зарлаж гүйцэтгэгчийг шалгаруулсан учир ондоо багтан хэрэгжээгүй;
- Хөвсгөл аймгийн Цагаан-Уул суманд ундны усны асуудлыг шийдвэрлэхэд хөрөнгө дутагдсан тул хийгдээгүй;
- Сэлэнгэ аймгийн Зүүнбүрэн суманд баригдах 75 ортой дотуур байрны барилгын 300.0 сая төгрөгийн үдб оны эцсээр нээгдсэн тул 2010 ий 2 дугаар пәдүй 27- іә оәіәәд сәдәәәйәі;
- Хөвсгөл аймгийн Ренчинлхүмбэ суманд төмөр хийцийн гүүр тавихаар “Сóóíú íúäúú” піїèіä 2009 ііä 3 удаа оәіәәд сәдәәйәі äíèíä- îdîëöîгч ирээгүй ооё 2010 онд дахин тәіәәд сәдәәйәі;
- Дундговь аймгийн сумдад ноос, ноолуур боловсруулах анхан шатны үйлдвэр барихад зориулсан санхүүжилтийн 75.0 сая төгрөгийг ноос ноолуурын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн урьдчилгаанд төлсөн;
- Төв аймгийн Сэргэлэн суманд бэлчээр хашиж, хамгаалах жижиг фермерийн төсөл оройтож эхэлснээс ондоо хэрэгжээгүй;
- Завхан аймгийн Тосонцэнгэл сумын 1200 хүний суудалтай спорт заалны барилгыг засварлах 49.5 сая төгрөгийн тендерт "Хан хөвч" ХХК шалгарч, санхүүжилтийг авсан боловч ажил нь ондоо багтаж эхлээгүй;
- Завхан аймгийн Эрдэнэхайрхан сумын хүүхдийн "Симба" цэцэрлэгийн барилгын их засварт 20.0 сая төгрөг "Цагаан сээр" ХХК-ийн дансанд орсон боловч санхүүжилт оройтож ирснээс ондоо багтаж засвар хийгдээгүй, 2010 оны 4 дүгээр сарын 20-ноос эхлэхээр гэрээ хийгдсэн байна.

3.10 2009 онд УИХ-ын гишүүдийн орон нутагт хэрэгжүүлэхээр санал болгосон төсөл, арга хэмжээний 17.1 хувь буюу 6839.7 сая төгрөгийг жижиг дунд үйлдвэрийг дэмжих болон аймаг, сумыг хөгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулахаар шийдвэрлэсэн байна. Тухайлбал:

- Н.Батбаяр гишүүний санал болгосон Архангай аймагт хэрэгжүүлж байгаа 500.0 сая төгрөгийн төсөл, арга хэмжээний эцсийн гүйцэтгэл бүрэн гарч ирээгүй;
- Х.Баттулга гишүүний санал болгосон ЖДҮДС-гаар дамжуулан хэрэгжүүлж байгаа мал нядалгааны үйлдвэр барих 500.0 сая төгрөгийн зээлийн гүйцэтгэл эцэслэн гараагүй;
- Ж.Энхбаяр гишүүний санал болгосон 200.0 сая төгрөгийг “Шинэ-Алтай”ХХК-д хүнсний битүү зах барихад зориулан эргэн төлөгдөх нөхцлөөр гэрээ байгуулан зээл олгосон,
- Ц.Дашдорж гишүүний санал болгосон 420.0 сая төгрөгийг ЖДҮ, хоршоо, фермерийн үйл ажиллагааг дэмжих зориулалтаар ХААН банкаар дамжуулан зээл олгосон;
- Ц.Сэдванчиг гишүүний санал болгосон 200.0 сая төгрөгийг ЖДҮДС-гаар дамжуулан Хөвсгөл аймгийн Мөрөнд самнасан ноолуурын үйлдвэр барихад зориулан зээл олгосон;
- Я.Батсуурь гишүүний санал болгосон 453.0 сая, П.Алтангэрэл гишүүний 400.2 сая, Л.Болд гишүүний 500.0 сая төгрөгийг ЖДҮДС-гаар, Ц.Шинэбаяр гишүүний 233.2 сая төгрөгийг Хас банкаар дамжуулан зээл олгосон;
- Д.Одхүү, Д.Дамба-Очир нарын тойрогтоо хэрэгжүүлэхээр санал болгосон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд зориулан МУХС-гийн хөрөнгөөс 1500.0 сая төгрөгийн санхүүжилт хийгдсэнээс Баян-Өндөр сумын Дэнж багт 40 ортой эмнэлгийн барилгад 190.0 сая, аймаг доторх автозамын шинэчлэлд 474.7 сая төгрөг хуваарилагдаж, үлдсэн 635.3 сая төгрөг “Эрдэнэт” санд төвлөрсөн;
- О.Чулуунбат гишүүний санал болгосноор Сэлэнгэ аймагт жижиг дунд бизнесийг дэмжих сан байгуулахад 500.0 сая, Д.Балдан-Очир гишүүний санал болгосноор Завхан аймагт сум хөгжүүлэх санд 63 сая, Д.Дондог гишүүний санал болгосноор “Өрхийн үйлдвэрлэлийг дэмжих сан”-г бүх сумдад байгуулахад 500.0 сая төгрөгийг тус тус олгожээ.

3.11 Орон нутгийн ЗДТГ, ИТХ-аар дамжуулан олгож байгаа зээл, эргэн төлөлт, гүйцэтгэгчид олгогдоогүй санхүүжилтийг орон нутгийг хөгжүүлэх санд төвлөрүүлсэн байна.

3.12 Орон нутгийг цахилгаан эрчим хүчээр хангах шугам бариулах, засвар хийх, барилга байгууламж барих, үйлдвэр байгуулах, тоног төхөөрөмж худалдан авах зэрэг зарим ажлыг нарийвчилсан тооцоо судалгаа хийж, техникийн нөхцөлийг бүрэн авч, зураг төсвийг бэлэн болгохгүйгээр захиалагчид ажлыг эхлүүлж байна. Тухайлбал:

- ОХУ-аас эрчим хүчээр холбогдсон Арцсуурь боомтоос 2007 онд Тэс сумыг холбохоор 10 квт-ын ЦДАШ-ыг 400,0 сая төгрөгөөр барьсан боловч ОХУ-аас цахилгааны эх үүсвэрээр хангахыг зөвшөөрөөгүйгээс ашиглалтгүй байсан учир 2009 онд Арцсуурь-Тэс сумын чиглэлд баригдсан ЦДАШ-ыг зөөж, Зүүнхангай сумаас Тэс сумыг холбоход 160,0 сая төгрөг зарцуулжээ.
- Говьсүмбэр аймагт хэрэгжүүлэх “Нийтийн аж ахуйн халуун усны барилгын засвар”-ын ажлын гүйцэтгэгчийг харьцуулалтын аргаар шалгаруулахад нэг компани материалаа ирүүлсэн байна. Үнэлгээний хорооноос тусгай

зөвшөөрлийг хуурамчаар үйлдсэн учир тендер шалгаруулалтыг хүчингүй болгожээ. Гэтэл тус компанитай аймаг шууд гэрээ байгуулан, санхүүжилт ирээгүй байхад урьдчилгаа олгосон ба уг барилгын засварын ажлын зураг төсөв бэлэн болоогүйгээс ажил зогсонги байдалтай байна.

- *Хэнтий аймгийн Өндөрхаан хотод “Сүүний үйлдвэрийн барилгын ажил гүйцэтгэх тухай” “Оргил констракшн” ХХК-тай хийсэн 300,0 сая төгрөгийн гэрээг аймаг баталгаажуулаагүй байгаа бөгөөд үйлдвэр нь ашиглалтад бүрэн ороогүй байна.*

3.13 Жил бүр их хэмжээний хөрөнгө зарцуулж байгаа боловч ажлын байр шинээр бий болсон, нэмэгдсэн, төрийн үйлчилгээний чанар, хүртээмж сайжирсан гэх мэт хөрөнгө оруулалтын үр өгөөж, үр нөлөөний талаар судалгаа, тооцоог аудитад хамрагдсан байгууллагууд хийгээгүй байна.

3.14 2009 онд хийсэн аудитаар зам, барилга, хөдөө аж ахуй, эрчим хүчний салбарын норм, нормативыг шинэчлэн боловсронгуй болгох талаар өгсөн зөвлөмжийг холбогдох яамд хэрэгжүүлээгүй байна.

3.15 Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа барилга байгууламж, техник, технологийн өргөтгөл, шинэчлэл, ашиглалтын үеийн их болон урсгал засвар, угсралттай холбоотой норм, норматив, стандартыг боловсронгуй болгох, шинэчлэх шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараахь дүгнэлт хийж байна. Үүнд:

1. Ондоо багтаж хийгдээгүй хөрөнгө оруулалтын санхүүжилтийн үлдэгдлийг төрийн санд буцааж төвлөрүүлэх ёстой. Гэтэл уг үлдэгдлийг хураалгахгүйн тулд хийгдээгүй ажлыг хийсэн мэтээр хуурамч гүйцэтгэл гаргаж, санхүүжилт авсан зөрчил арилахгүй байна. Үүнд олон хүчин зүйл нөлөөлж байгаагийн дотроос дараахь асуудалд анхаарах шаардлагатай байна:

- Гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендер сунжирч хугацаа алдах болон бусад шалтгаанаар хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламж дулааны улиралд буюу ондоо багтаж хийгдэхгүй тохиолдол байна. Түүнчлэн зарим компани олон тендерт гүйцэтгэгчээр шалгарч, хүчин чадал, хөрөнгө нөөц нь хүрэлцээгүйгээс гэрээт ажлыг хугацаанд нь гүйцэтгэж чадаагүй явдал ч гарч байна. Эдгээрээс гадна оны дундуур төсөвт тодотгол хийдэг нь санхүүжүүлэгч, захиалагч байгууллагын хувьд зарим талаар хүлээлт бий болгож, хөрөнгө оруулалтын хэрэгжилтэд цаг хугацаа алдах нэг нөхцөл болж байна.
- Хөрөнгө оруулалтын санхүүжилтийг цаг тухайд нь шуурхай шилжүүлж байхад анхаарах хэрэгтэй байна.
- Барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын болон техникийн комиссууд эрх, үүргээ бүрэн хэрэгжүүлж, хариуцлагатай ажиллаж тэр бүр чадахгүй байна. Зарим барилга байгууламжийг ашиглалтад оруулах улсын комисс хуурамч акт үйлдсэн ноцтой зөрчил илэрлээ.

2. МУХС-гийн 2009 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар “Авто зам, барилга, эрчим хүчний салбарт 2008 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтөөр нэмэгдсэн зардлын жагсаалт”-ыг баталсан. Гэтэл Сангийн яам салбар, объектуудад хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээнд үнийн өсөлтөөр нэмэгдсэн материалын зардлыг олгохдоо харилцан адилгүй шийдвэрлэсэн байна.

3. Хууль тогтоомж зөрчсөн байгууллага, албан тушаалтан, гэрээгээ биелүүлээгүй гүйцэтгэгч компанид хүлээлгэх хариуцлага сул байгаа нь тендерийн болон төсвийн холбогдолтой хууль тогтоомж хэрэгжихгүй байхад нөлөөлж буй нэг хүчин зүйл болж байна.

4. Төсвийн хөрөнгө оруулалтын мөнгөөр зарим аж ахуйн нэгж, иргэдэд буцалтгүй тусламж үзүүлэх, хөрөнгө оруулалтын шинж чанартай бус арга хэмжээнд зарцуулах явдал байна.

5. Хөрөнгө оруулалтаар бэлтгэж аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зарим техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн үнэ эргэж төлөгдөх үед түүнийг хаана, хэрхэн төвлөрүүлж, зарцуулах асуудал журамлагдаагүй байна.



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Нэгдсэн үндэстний гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/Факс: (976-51) 26-02-47, http://www.mof.gov.mn

2010.5.28 № 3-4/2751
танай 2010.5.10 -ны № 451 -т

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАРТ

Аудитын тайлангийн төсөлд
санал өгөх тухай

Үндэсний аудитын газраас Улсын төсөв, Монгол Улсыг хөгжүүлэх сангийн хөрөнгөөр 2009 онд хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд аудит хийсэн тайлангийн төсөлтэй танилцаж Сангийн сайдад ирүүлэх зөвлөмж болон Сангийн сайдын багцад хэрэгжсэн зарим төсөл арга хэмжээний талаар тайланд туссан дүгнэлтүүдэд тайлбар хийж хавсралтаар хүргүүлж байна.


Сангийн сайдад өгөх зөвлөмжийн Нэгдүгээр заалтад тусгагдсан дүгнэлттэй санал нэг байгаа бөгөөд энэ талаар гарч буй хүндрэлүүдийг шийдвэрлэх хууль зүйн зохицуулалтыг УИХ-д өргөн барих "Төсвийн тухай", "Төсвийн тогтвортой байдлын тухай" хуулийн төсөлд тусгаад байна.

Харин хөрөнгө оруулалтын тухайн жилд батлагдсан хөрөнгийн ашиглаж амжаагүй үлдэгдлийг дараагийн жилд үргэлжлүүлэн зарцуулах нь санхүүгийн жилийг хоёр буюу түүнээс дээш жилээр сунгаж буй мэт ойлгогдох бөгөөд ийм зохицуулалт хийх нь хөрөнгө оруулалтын гүйцэтгэл тавих хяналтыг сулруулах, гүйцэтгэчийг наазгай байдалд түлхэх үр дагавартай тул гүйцэтгэлийг сайжруулах шинэ боломжийг судлан үзэж дайчилсны дараа авч үзэхийг мэргэжилтнүүд зөвлөж байгаа юм.

Сангийн сайдад өгөх зөвлөмжийн 3,4,5,6 дугаар заалтууд болон аудитын тайланд хийсэн дүгнэлтүүд нь нийтдээ "Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай" хуулийн 12 дугаар зүйлээр төсвийн ерөнхийлөн захирагчдад олгогдсон бүрэн эрхийн хүрээний асуудлууд тул Төсвийн ерөнхийлөн захирагч тус бүрд нь тодорхой зөвлөмж хүргүүлж үр дүнг тооцож байх саналтай байна.

Тайлбар 1-ийг үзнэ үү.

ДЭД САЙД



Т.ОЧИРХҮҮ

. 08 2394

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

ҮАГ-аас Улсын төсөв, МУХС-ийн хөрөнгөөр 2009 онд хийсэн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд хийсэн аудитын тайланд Сангийн сайдын багцтай холбоотой тусгагдсан зарим асуудалд өгөх тайлбар

Тайлбар 2-ыг үзнэ үү.

2.20 Авто зам, барилга, эрчим хүчний салбарт 2008 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөжлтөөр нэмэгдсэн зардал дунджаар 27 хувь байхад зарим гүйцэтгэгчид олгосон үнийн өсөлтийн зардал харьцангуй өндөр байна. Тухайлбал: ... ҮТЕГ-ын конторын барилгад 90,1 Сангийн яамны конторын барилгад 86,4 хувиар тооцож олгосон байна.

Тайлбар: 2008 оны төсвийн тухай хуулиар Сангийн яамны Төрийн сан, мэдээллийн төвийн конторын барилгад 1732,8 сая, Татварын Ерөнхий газрын конторын барилгад 1724,3 сая төгрөгийн санхүүжилтийг баталж, санхүүжилтийг бүрэн олгосон болно. Эдгээр барилгуудад журмын дагуу 2008 онд олгосон санхүүжилтийн гүйцэтгэлд үндэслэн үнийн зөрүүг тооцсон бөгөөд Сангийн яамны Төрийн сан, мэдээллийн төвийн конторын барилгад 391,0 сая, Татварын Ерөнхий газрын конторын барилгад 353,3 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон юм. Энэ нь эдгээр барилгуудад 2008 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын хувьд Сангийн яамны Төрийн сан, мэдээллийн төвийн конторын барилгад 22,6 хувь, Татварын Ерөнхий газрын конторын барилгад 20,5 хувь болж байна.

/мян.төг/

№1	Барилга, байгууламжийн нэр, байршил, хүчин чадал	Хэрэгжүүлэх хугацаа	2008 оны төлөвлөгөөгөөр	БУА	Санхүүжилт
1	Төрийн сан, мэдээллийн төвийн өргөтгөлийн барилга	2007-2010	1732800.0	60%	2042500.0
2	ҮТЕГ-ын конторын барилга.	2007-2010	1724300.0	60%	2424300.0

Тайлбар 2-ыг үзнэ үү.

2.21 Зарим салбарт тендерт шалгарсан компаниуд барилгыг хугацаанд нь ашиглалтад оруулахгүй, төсөвт өртгийг жилээс жилд өсгөн нэмэгдүүлэх байдал ажиглагдаж байна.

А. САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН САН, МЭДЭЭЛЛИЙН ТӨВИЙН БАРИЛГЫН ТАЛААР

Сангийн яамны Мэдээллийн төвийн барилга нь 540 м² /18мх30м/ талбай бүхий 10 давхар каркасан бүтээцтэй барилга юм. Сангийн яамнаас 2007 оны 07 сарын 25-нд зарласан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерт "ПУМА" ХХКомпанийг хамгийн бага үнийн саналаар /2007 оны 8 сарын 30-ны үнэлгээний хорооны хурлаар/ шалгаруулжээ. Улмаар Сангийн яам, "ПУМА" ХХК-ийн хооронд 2007 оны 10 сарын 18-нд байгуулсан гэрээгээр БУА-ыг 2398,0 сая төг-өөр ажлын 265 хоногт багтаан 2008 оны 12 сарын 29-нд ашиглалтанд оруулахаар тохиролцсон байна.

ХОЛБОГДОХ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ

Дээрхи барилгыг гэрээ ёсоор 2007 оны 10 сард эхэлсэн боловч өвлийн улиралд хөрсний овойлт үүсч болох газар дээр баригдаж байгаа тул ажлыг зогсоож 2008 оны 4 сарын 17-ноос үргэлжлүүлэн барьсан бөгөөд хүйтний улирал эхэлсэнтэй холбогдуулан мөн оны 11 сарын 15-нд ажлыг зогсоосон болно.

Мөн хугацаанд Сангийн яамны Барилга захиалагчийн алба 2008 оны 04 сарын 01-нээс байгуулагдаж, Ерөнхий захиалагч Сангийн яамны өмнөөс барилгад техникийн хяналт, санхүүжилтийн гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан.

БУА-ын явцад санхүүжилтийн хувьд дараах хүндрэлтэй асуудлууд гарч ирсэн. Үүнд:

1.Тендер шалгаруулалтын болон зургийн анхны даалгаварт дутуу тусгагдсан барилгын талбай чөлөөлөх барилга буулгах ажил /Хуучин төрийн сангийн барилга/, агааржуулалтын эйр кондишны угсралтын ажил, гадна дулааны холболтын төв зам сэтлэх ажил, 4 ш лифтний угсралтын зардал түүнд холбогдох барилгын хийцийн өөрчлөлт, овойлттой хөрсөнд баригдах суурийн өөрчлөлтийн зардал (5 яам) ойр орчмын барилгуудын дулааныг шинээр баригдах мэдээллийн төвийн төв узельд холбох шаардлагаар дулааны эх үүсвэрт шинээр нэмэгдэх ялтсан бойлорын хүч чадал өссөнтэй холбогдох зардал, дотоод сүлжээний хэрэглээний дутуу тусгагдсан зардал

2. Дээрхи ажлын явцад материал, бензин шатахууны үнийн өсөлттэй холбоотой үнийн зөрүү

3. Барилга хот байгуулалтын сайдын 2007 оны 12 сарын 21-ний 210 тоот тушаалаар батлагдсан “Зам, барилгын ажилчдын цагийн тарифт цалингийн жишиг” үнийн өсөлт.

4. Барилгын ерөнхий гүйцэтгэгчээр шалгарсан “ПУМА” ХХК-ийн тендерт шалгарсан төсөвт материалын үнэ тухайн үеийн үнэ ханшаас хэт доогуур тусгаж үнийн болон ажлын тоо хэмжээ зөрүү их гарсан. Тухайлбал:

№	Төрөл	Хэмжих нэгж	Тендерийн үнэ	Тухайн 2007 оны ханш	Одоогийн зах зээлийн ханш
1	Бетон зуурмаг БМ 300	м	48000	90000	112000
2	Арматур	тн	780000	925000	1250000
3	Тоосго	ш	93	180	220
4	Хөнгөн блок	м ³	49800	68000	99600
5	Шилэн фасад	м ²	75000	120000	800000
5	Өнгөлгөөний чулуу	м ²	29000	85000	228000
7	Вакуум цонх	м ²	50000	60000	280000

ГЭХ МЭТ.

Дээрх шалтгааны улмаас захиалагч, гүйцэтгэгчийн хооронд байгуулах нэмэлт өөрчлөлтийн гэрээг хууль эрх зүйн дагуу байгуулахад анхаарч, ажиллаж байна.

Тайлбар 2-ыг үзнэ үү.

Б. ҮТЕГ-ЫН КОНТОРЫН БАРИЛГА УГСРАЛТЫН ТАЛААР

ҮТЕГ-ын конторын барилгын барилга угсралтын ажлын (БУА) гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендерт "Пума" ХХК шалгарч, БУА-ыг 2007 оны 08-р сарын 31-ний өдөр ажил эхэлсэн бөгөөд, 2008 оны 11-р сарын 30-ны өдөр дуусгаж ашиглалтад өгөх, нийт төсөвт өртөг 2400,0 сая төгрөг байхаар харилцан тохирч захиалагч, гүйцэтгэгч талууд 2007 оны 08-р сарын 24-ний өдөр гэрээ байгуулсан байна.

Улсын мэргэжлийн хяналтын газраас 2007 оны 09-р сарын 19-ний өдөр барилга угсралтын ажил эхлүүлэх 125/2007 тоот зөвшөөрөл авч, хуучин барилгын талбай чөлөөлөх /СБД-ийн ТХ-ийн конторын болон гаражын барилгуудыг буулгах, инженерийн шугам сүлжээ зайлуулах/, НТГ-ын дулааны түр шугам сүлжээг хийх ажлуудыг хийж эхэлсэн.

Хөрсний ус дээшилж, суурь хөрс хөлдөж, бетон цутгалтын ажил хийх боломжгүй болсны улмаас УМХГ-ын 07/171/886 тоот акт, захиалагч, гүйцэтгэгч, зургийн байгууллагын хамтарсан хурлын протоколыг үндэслэн 2007 оны 10-р сарын 31-ээс 5-н сарын хугацаагаар БУА-ыг түр зогсоосон нь гэрээний хугацаа хойшлох гол шалтгаан болсон.

Захиалагч гүйцэтгэгч талууд БУА-ын явц, цаашид авах арга хэмжээний тухай хэлэлцсэн асуудлаар өнгөрсөн хугацаанд гэрээнд 2 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан болно.

Тайлбар 2-ыг үзнэ үү.

В. ҮНИЙН ЗӨРҮҮГИЙН АСУУДЛААР

Гүйцэтгэгч "Пума" ХХК-аас 2009 онд Сангийн яаманд ирүүлсэн гүйцэтгэлийн төсөвт нэмэгдэл ажил, цалин, материал, тээвэр, механизмын үнийн өсөлт, цаашид хийгдэх БУА-ын төсөвт өртгийг зах зээлийн өнөөгийн байдалтай уялдуулан тооцож батлагдсан төсөвт өртгөөс гадна Сангийн яамны барилгад 4,1 тэрбум, Татварын барилгад **3,4 тэрбум** төгрөгийн санхүүжилтийн асуудлыг хянаж шийдвэрлэсэн. Үүнд: Монгол Улсын 2009 оны төсвийн тухай хуулиар Сангийн яамны Төрийн сан, Мэдээллийн төвийн барилгад 1 тэрбум, Монгол Улсын 2010 оны төсвийн тухай хуулиар Сангийн яамны Төрийн сан, Мэдээллийн төвийн барилга, Татварын ерөнхий газрын конторын барилгад тус бүр 1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон.

УИХ-ын 2009 оны 27 дугаар тогтоолын дагуу материалын үнийн зөрүүд МУХС-аас Сангийн яамны Төрийн сан, мэдээллийн төвийн конторын барилгад олгосон 391,0 сая, Татварын Ерөнхий газрын конторын барилгад олгосон 353,3 сая төгрөгийн тухайд энэ хөрөнгө эдгээр барилгын нийт төсөвт өртгийн дүнд орж гүйцэтгэл гарах бөгөөд харин гэрээг тусад нь байгуулж, санхүүжүүлэх нь зүйтэй талаар хуульчдын саналыг авч ажилласан. Энэ талаар өмнө аудитын байгууллагын холбогдох хүмүүст тайлбар өгсөн болно.

+
Тайлбар 2-ыг үзнэ үү.

г. 3.3 Төсвийн хөрөнгөөр бэлтгэгдсэн хөрөнгийн эх үүсвэрийн тодорхой хувийг эргэн төлөгдөх нөхцөлгүйгээр бусдад олгох, үнэ төлбөргүй өгөх, үр ашиггүй үрэлгэн зарцуулах явдал арилахгүй байна. Тухайлбал: Гаальчдийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх 2910,5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 60 айлын орон сууцны 47-г сангийн яамны албан хаагчдад, 13-ыг ГЕГ-ын албан хаагчдад үнэ төлбөргүй олгожээ... гэжээ

Монгол Улсын Их Хурлаас 2002 оны 6 дугаар сарын 28-ны өдөр шинэчилэн баталсан "Төрийн албаны тухай" хуулинд төрийн байгууллагаас төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, баталгаа болон төрөөс орон байраар хангах зэрэгт чиглэсэн хөтөлбөр боловсруулж, тэдгээрийн талаар хэрэгжүүлэх ажлыг уялдуулан зохицуулахаар заасан.

Төрийн албан хаагчийн нийгмийн баталгааг хангах авч хэрэгжүүлж буй арга хэмжээ нь албан хаагчдыг орон сууцаар хангах, тэдний цалин хөлсийг нэмэгдүүлэх, мэргэжлээ дээшлүүлэхэд нь төрийн зардлаар сургах, эрүүл мэндийн болон нийгмийн даатгалын хураамжийн зохих хувийг төр хариуцах, төрийн албан хаагчийн нэг хүүхдийн их, дээд, мэргэжлийн сургуульд суралцах сургалтын зардлыг төрөөс төлөх, ээлжийн амралтаар өөрийн болон эхнэр /нөхрийн/ төрсөн нутаг явах үед замын зардлыг автомашин, төмөр замын үнэлгээгээр бодож, 2 жилд нэг удаа олгох зэрэг үйл ажиллагаанд чиглэгдэж байна.

Сангийн яамнаас дээрх асуудлыг хэрэгжүүлэх зорилтын хүрээнд Төрийн захиргааны төв байгууллагуудын дотроос анх удаа олон жилийн хугацааг хамарсан "Сангийн яамны Хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр (2007-2016 он)"-ийг боловсруулан Төрийн нарийн бичгийн даргын 2006 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 180 дугаар тушаалаар батлаж, уг хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Энэхүү хөтөлбөрийн зорилго нь Сангийн яамны төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, тэдний мэргэжил мэдлэгийг тасралтгүй дээшлүүлэх, эрүүл мэндийг нь хамгаалахтай холбогдсон асуудлыг шийдвэрлэж, хэрэгжүүлэхэд оршиж байгаа бөгөөд Төрийн албан хаагчид орон сууцны нөхцөлөө сайжруулах, орон байраар хангахад дэмжлэг үзүүлэх талаар тодорхой тусгасан.

Сангийн яам болон гаалийн ажилтнуудын 60 айлын орон сууцыг энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний хүрээнд барьж ашиглалтад оруулсан болно.

ТАЙЛБАР

Тайлбар 1	Сангийн яамнаас ирсэн саналыг хүлээн авлаа.
Тайлбар 2	Сангийн яамнаас ирсэн бусад саналыг хүлээн авах боломжгүй болно.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Нэг. Монгол Улсын Ерөнхий сайд С.Батболдод:

1. Тендерийн болон төсвийн холбогдолтой хууль тогтоомж зөрчигсдөд хүлээлгэх хариуцлагыг чангатгах, тухайлбал, хууль тогтоомж зөрчсөн нь төрийн албан хаагчийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх үндэслэл болдог байх, гэрээгээ биелүүлээгүй гүйцэтгэгч компанийг тендерт дахин оролцох эрхийг нь хасах хүртэл шийтгэл оногдуулахаар холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах санал боловсруулж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;
2. Улсын төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид хамаарах зүйлсийг тодорхой болгож, хөрөнгө оруулалтын шинж чанартай биш зүйлийг төлөвлөгөөнд тусгахгүй байх талаар холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулах арга хэмжээ авах;
3. Оны дундуур төсөвт тодотгол хийхгүй байхад анхаарч, төсвийн төлөвлөлтийн үндэслэлийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
4. Өвлийн улиралд тендер шалгаруулалтыг зохион байгуулж, хавар дулаарч эхэлмэгц барилга угсралт, бүтээн байгуулалтын ажлыг цаг алдалгүй эхлүүлж байх боломжийг бүрдүүлэх үүднээс төсөв, санхүүгийн жилийг оновчтойгоор тогтоох асуудлыг судалж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;
5. Төсвийн хөрөнгөөр зарим аж ахуйн нэгж, иргэдэд эргэн төлөгдөх нөхцөлгүй, буцалтгүй тусламж үзүүлж байгааг эргэн харж, зах зээлийн харилцааны нөхцөлд тохирсон төрөөс дэмжлэг үзүүлэх оновчтой арга хэлбэрийг ашиглах.

Хоёр. Сангийн сайд С.Баярцогтод:

1. Ондоо багтаж хийгдээгүй хөрөнгө оруулалтын санхүүжилтийн үлдэгдлийг буцааж төвлөрүүлдэг одоогийн практикийг эргэн харж, нэгэнт эхэлсэн ажлыг нь шуурхай дуусгуулах, цаг хугацаа алдахгүй, нэмэгдэл зардал чирэгдэл гаргахгүй байх үүднээс зарцуулагдаагүй хөрөнгийн үлдэгдлийг түр дансанд төвлөрүүлж, ажлын гүйцэтгэлээр нь санхүүжүүлэн, тусад нь тайлагнаж байх эрх зүйн орчинг бий болгох асуудлыг судалж, зохих журмын дагуу шийдвэрлүүлэх;
2. Хөрөнгө оруулалтаар бэлтгэж аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд олгосон зарим техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, бусад хөрөнгийн үнэ эргэж төлөгдөх үед түүнийг хаана, хэрхэн төвлөрүүлж, зарцуулах асуудлыг журамлах;
3. Тендерийн холбогдолтой хууль тогтоомж зөрчсөн, гэрээний үүргээ биелүүлээгүй гүйцэтгэгч компаниудын бүртгэл хөтлөн, тендерт дахин оролцох эрхийг нь тодорхой хугацаагаар хасах хүртэл арга хэмжээ авч ажиллах;
4. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тендерт шалгарсан гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, давагдашгүй хүчин зүйлээс бусад эрсдэлийг өөрөө тооцож, хариуцаж байх зарчим баримтлаж байх;
5. Хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний үр дүнг тооцож ажиллах.

Гурав.Төсвийн ерөнхийлөн захирагч нарт:

1. Барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах улсын болон техникийн комиссын хүлээх үүрэг, хариуцлагыг нэмэгдүүлэх, тэдэнд тавих хяналтын тогтолцоог бүрдүүлэх, хуурамч акт гаргасан комиссын дарга, гишүүдэд хариуцлага тооцох;
2. Хөрөнгө оруулалтын санхүүжилт олгохдоо гүйцэтгэгчтэй хуйвалдан хийгдээгүй ажилд хуурамч гүйцэтгэл гаргаж олгодгийг зогсоож, түүнд тавих дотоод хяналтыг сайжруулах
3. Хөрөнгө оруулалтын үр өгөөжийг дээшлүүлэхийн тулд үе шатны хяналтыг сайжруулах, гүйцэтгэлийг үнэн зөвөөр гаргах, тайлагнах арга замыг боловсронгуй болгох;
4. Хөрөнгө оруулалтыг хангалтгүй зохион байгуулсан ажилтнуудад хариуцлага тооцох;
5. Улсын төсөв болон сангийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар тодорхой ажил зохион байгуулж, үр дүнг эргэж мэдээлж байх.

Улсын төсөв болон МУХС-ийн хөрөнгөөр 2009 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний батлагдсан төсөв, гүйцэтгэлийг хөрөнгийн эх үүсвэр болон бүтцээр ангилсан судалгаа

(сая төгрөгөөр)

№	2009 онд хийгдсэн хөрөнгө оруулалтын		Нэгдсэн дүн						
	Эх үүсвэр	Бүтэц	Төсөвт өртөг	Батлагдсан төсөв 2009		Гэрээний дүн	Гүйцэтгэл	Зөрүү	
				Хуулиар	Тодотгосон				
1	Улсын төсөв	Барилга, байгууламж	шилжих	606,605.3		138,290.0	118,190.6	118,190.6	20,099.4
			шинээр	75,325.6		70,634.9	63,581.6	63,581.6	7,053.3
		Их засвар		12,346.0		12,406.2	11,589.9	11,589.9	816.3
		Тоног төхөөрөмж		20,792.0		20,421.8	20,352.0	20,352.0	69.8
		Дүн		715,068.9	409,141.3	241,752.9	213,714.1	213,714.1	28,038.8
2	МУХСан	Барилга, байгууламж	шилжих	101,888.7	122,289.3	35,769.6	24,761.5	24,761.5	11,008.1
			шинээр	144,007.1		121,677.0	114,193.1	114,193.1	7,483.9
		Их засвар							
		Тоног төхөөрөмж		19,487.5		9,187.7	9,187.7	9,187.7	
		Дүн		265,383.3	122,289.3	166,634.3	148,142.3	148,142.3	18,492.0
	Дүн		980,452.2	531,430.6	408,387.2	361,856.4	361,856.4	46,530.8	

Жич: Нэгдсэн судалгааны улсын төсөв, МУХС-ийн дүнг Сангийн яамны гүйцэтгэлээр тооцлоо.

(Хавсралт № 2)

Улсын төсөв, МУХС-гийн төсвийн хөрөнгөөр санхүүжсэн хөрөнгө оруулалтын төсөл,
арга хэмжээ барилга байгууламжийн тендерт шалгарсан аж, ахуйн нэгж байгууллагын судалгаа

№	Гүйцэтгэгч байгууллагын нэр	Санхүүжилт авсан дүн	Ажил үйлчилгээний тоо	Төсвийн ерөнхийлөн захирагч
1.	"Хөхтэнгэр хөвсгөл" ХХК	433,6	2	БСШУС
2.	"Хөх бүрдний эх" ХХК	475,2	2	БСШУС
3.	"Хар хорин өргөө" ХХК	311,4	4	БСШУС
4.	"Синчи Ойл" ХХК	875,0	2	БСШУС
5.	"Алтанбулаг трейд" ХХК	1026,2	3	БСШУС
6.	"Аривжих увс" ХХК	458,5	2	БСШУС
7.	"Урагшлах" ХХК	1176,1	3	БСШУС
8.	"Төмөр хүлэг" ХХК	894,0	3	БСШУС
8.	"Комп трейд" ХХК	330,5	3	БСШУС
10.	"Материал трейд" ХХК	574,7	2	БСШУС
11.	"Бетон арматур" ХХК	718,8	2	БСШУС
12.	"Хөвсгөл геологи" ХХК	941,2	2	БСШУС
13.	"Хар чоног" ХХК	304,3	2	БСШУС
14.	"Боорчи" ХХК	523,5	2	БСШУС
15.	"Көшелик" ХХК	676,8	2	БСШУС
16.	ШШГЕГ	1550,0	4	ХЗДХС
17.	"Дагшин Оргих" ХХК	38,4	2	БОАЖС
18.	"Интерсайнс" ХХК	120,5	2	ЭМС, ЕС
19.	"Эм Си Пи Си жи ар" ХХК	384,8	3	ЗТБХБС
20.	"Агромаштех" ХХК	900,0	2	ХХААХУС
21.	"Сетунари" ХХК	551,1	2	ЭМС
22.	"ЧБЧБ" ХХК	19,1	2	ҮСХД
23.	"Лос Максине" ХХК	49,3	2	БОАЖС
24.	"Линк бридж" ХХК	27,4	2	ЕС
25.	"Батшинд аюу" ХХК	399,5	2	ЕС
26.	"Бамбай хурд" ХХК	11,0	2	ШС, БОАЖС
27.	"Салхины эрч" ХХК	120,6	2	СС
28.	"Цацрах цог" ХХК	328,5	3	ЭБЭХС
29.	"Пи Эм" ХХК	115,5	2	ЭМС
30.	"Эрин говь" ХХК	57,0	2	ҮСХД
31.	"Эрчмийн Ундраа" ХХК	6,0	2	ЭБЭХС
32.	"Топика" ХХК	427,6	4	УИХ, СС
33.	"Санжбилэг" ХХК	57,0	3	ҮСХ

34.	"Лабтех" ХХК	901,8	3	ЭМС
35.	"Мед монгол" ХХК	275,7	2	ЭМС, ХЗДХС
36.	"Орбитнет" ХХК	9424,8	4	ЗТБХБС, СС
37.	Баянхайрхан чоно ХХК	1435,4	3	БХС, ХЗДХС
38.	"Ай Си Ти Сайн" ХХК	363,6	2	ЗТБХБС
39.	"Аганист" ХХК	639,3	2	ЭМС
40.	"Аржкапитал" ХХК	1150,7	2	ЗТБХБС
41.	"Бисофт констракшн" ХХК	885,1	3	ЭМС
42.	"Сэлба" ХХК	11,7	4	УИХ
43.	"Тэнгэр уул" констракшн	892,4	2	ЭБЭХС
44.	"Саммит" ХХК	391,9	7	ЕС, БОАЖЯ, ҮСХД, ШС, СС
45.	"Цамхаг констракшн" ХХК	133,0	2	ЭМС, ХЗДХС
46.	"БЦХ" ХХК	186,3	2	ЭМС
47.	"Мед импекс интернейшл" ХХК	467,2	4	ЭМС, ШС, ХЗДХС
48.	"Хурд Авто" ХХК	816,3	4	БОАЖС, ЭМС
49.	"Мигма электроникс" ХХК	222,1	5	УИХ, ШС
50.	"То системс" ХХК	39,8	2	БОАЖС
51.	"Насны зам" ХХК	1787,8	2	ЗТБХБС
52.	"Бодь электроникс" ХХК	158,3	3	СС, ҮСХД
54.	"Баян констракшн" ХХК	180,3	3	ЭБЭХС
55.	"Алтай трест" ХХК	109,2	3	ЗТБХБС
56.	"Альянс-Тех" ХХК	1151,6	4	ЭМС, ЭБЭХС, ЗТБХБС
57.	"Автоблок" ХХК	70,8	2	БОАЖЯ, ШС
58.	Бө"Мурап"ХХК	221,4	2	БОАЖЯ, ХХААХҮС
59.	"Заан соёо" ХХК	148,8	2	ЗТБХБС
60.	"Энерго сервис монтаж"	1767,0	3	ЭБЭХС
61.	"Хасу эрчим" ХХК	1295,9	2	ЭБЭХС
62.	"Хурдны зам" ХХК	7190,6	5	ЗТБХБС
63.	"Монроуд" ХХК	10677,6	4	ЗТБХБС
64.	"Заабар" ХХК	4554,9	4	ЗТБХБС, ХХААХҮС
65.	"Аморе интернейшнл" ХХК	1254,1	4	ЭБЭХС, ЗТБХБС, СС
66.	"Да хот" ХХК	43,9	2	ЭБЭХС
67.	"СММС" ХХК	1010,1	2	ЭБЭХС
68.	"Нью прогресс" ХХК	71,3	2	ЭБЭХС
69.	"ЦОМА" ХХК	1000,0	2	ХЗДХС
70.	"Бридж" констракшн	1008,1	2	ЭМС, ЗТБХБС

71.	"ЭХБУТ" ХХК	3396,9	6	ЭБЭХС
72.	"Илч хангай" ХХК	5462,7	9	ЭБЭХС
73.	"Буурал Сугай" ХХК	110,4	3	ЭМС, ЗТБХБС
74.	"ССТ-Од" ХХК	324,9	2	ХХААХҮС
75.	"MCS электроникс" ХХК	1191,9	11	ЕС, БОАЖС, УИХ, ШС, ЭБЭХС
76.	"Тэмээн" ХХК	276,7	3	ЭМС
77.	"Үүрэг трэйд" ХХК	1340,0	2	ЭМС
78.	"ЧММ" ХХК	1753,7	4	ЭМС, ЗТБХБС
79.	"Мон-Аз" ХХК	150,2	2	ЗТБХБС
80.	"Сүлжээ" ХХК	8,6	2	БОАЖС
81.	"Өгөөж хишиг" ХХК	251,0	2	ЭМС, ХЗДХС
82.	"Баярс констракшн" ХХК	2991,1	2	НХХС, СС
83.	"Гацуурт" ХХК	5346,7	2	ЗТБХБС, ХХААХҮС
84.	Төв "Тунгалаг-Ус" ХХК	306,0	4	ХХААХҮС
85.	"Анун" ХХК	35,5	2	ЕС, ХЗДХС
86.	"НАБСАН" ХХК	1937,7	2	ЗТБХБС
87.	"Хөвсгөл зам" ХХК	1268,6	2	ЗТБХБС
88.	"Хөвсгөл геологи" ХХК	1116,1	2	ЭМС, ХЗДХС
89.	"Очир төв" ХХК	189,9	3	ЗТБХБС
90.	"Боорчи" ХХК	1635,2	2	ЭБЭХС
91.	"САН" ХХК	770,9	3	ЭМС, ЭБЭХС, ЗТБХБС
92.	"Одкон Холдинг" ХХК	4296,1	5	ЭБЭХС, ЗТБХБС, ШС, СС
93.	Дорнод "Чандмань тал" ХК	596,2	3	ХХААХҮС
94.	"Жол" ХХК	1639,1	2	ЗТБХБС
95.	"МВС" ХХК	730,0	2	ЭМС, НХХС
	Дүн	103948,0	263	

Зөрчил дутагдлын улмаас хугацаандаа бүрэн хэрэгжих боломжгүй болсон төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн талаарх судалгаа

(сая төгрөгөөр)

№	Захиалагч байгууллага	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Гүйцэтгэгч байгууллагын нэр	Хугацаа	Батлагдсан төсөв	Санхүүжих дүн	Гүйцэтгэл дүн	Зөрүү	Ажлын гүйцэтгэлийн хувь	Гүйцэтгэл дутуу байгаа шалтгаан:				Зөрчил дутагдлын үндэслэл, шалтгаан
										Дутуу, огт хийгдээгүй	Нэмэлт төсөв шаардагдсан	Ажлын явц, чанарын шаардлага хангаагүй	Ажиллах хүч, техник хангамж дутагдсан	
1	БСШУЯ	Сургууль 640 суудал, спортын заал (Увс, Улаангом)	"Алтай трест" ХХК	2006-2009	1,552.2	1,552.2	1,542.2	10.0	90	x	x			Үнийн өсөлтийн улмаас гэрээт хугацаандаа ашиглалтад ороогүй. Гүйцэтгэгч үнийн зөрүү 112,3 сая төг авсан ба хүйтний улирал болж технологийн шаардлагаар зогссон. 2010 оны 2 дугаар улиралд багтааж дуусгахаар шийдвэрлэсэн.
2	БСШУЯ	Коллежийн барилгын шинэчлэл (Увс, Улаангом)	"Дэлгэр констракшн" ХХК	2007-2009	730.0	730.0	710.0	20.0	70	x	x			БУА-ыг 2007 онд эхэлсэн, 2008 онд үнийн өсөлтөөс шалтгаалж барилгыг дуусгаагүй. А блокны ханын өрөг хучилт, Б блок карказ цутгалт болон хоёр давхарын өрөг хийгдсэн. Үнийн зөрүү 39,1 сая төгрөг батлагдсан боловч гүйцэтгэгч компани уг хөрөнгөөр барилгыг дуусгах боломжгүй гэж үзэж хүлээж аваагүй. 2009 онд үнийн зөрүүнээс шалтгаалан ажил эхлээгүй зогссон. үлдэгдэл 435,2 сая төгрөг шаардлагатай гэж үзсэн тул экспертизийн дүгнэлт гаргуулахаар шийдвэрлэжээ.
3	Өмнөговь аймгийн ЗДТГ	Соёлын төвийн барилга (Өмнөговь, Цогт-Овоо)	"Зос трейд" ХХК	2008-2009	486.0	486.0	486.0		70	x	x			2010 оны төсөвт 190,0 сая төгрөг батлагдсан. Нэг давхарын БУА дуусч, 2 дугаар давхарын карказын арматурчилалын ажлыг дууссан байна. Орон нутагт тендер зарлагдаж гүйцэтгэгч шалгаруулахдаа барилга угсралтын ажлын зураг төслийг бүрэн судлаагүй ажил орхигдуулснаас нэмэгдэл зардал шаардлагатай болсон байна.
4	Өмнөговь аймгийн ЗДТГ	Соёл, спортын төвийн барилга (Өмнөговь, Мандал-Овоо)	"Аж констракшн" ХХК	2008-2009	393.8	393.8	393.8		76	x	x			Орон нутагт тендер зарлаж гүйцэтгэгч шалгарсан. Нэмж 50,0 сая төгрөг шаардлагатай гэсэн тооцоолол гаргажээ.
5	Хөвсгөл аймгийн ЗДТГ	Цэцэрлэгийн барилга (Хөвсгөл, Рашаант)	"Хөх тэнгэр Хөвсгөл" ХХК	2008-2009	314.8	314.8	314.8		80	x	x			Орон нутагт эрх шилжсэн. 2009 онд экспертизээр төсөвт өртөг 495.6 сая төгрөг болсон, нэмэлтээр 181.6 сая төгрөг шаарлагатай болж, 2010 онд аймгийн Засаг даргын багцад 50,0 сая төгрөг батлагдсан байна.
6	Булган аймгийн ЗДТГ	Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн дотуур байр, 100 ор, (Булган, Булган сум)	"Төмөр хүлэг" ХХК	2008-2009	494.6	494.6	445.1	49.5	85	x				Орон нутагт эрх шилжсэн. 2009 оны 10-р сарын 15-нд ашиглалтад оруулах байсан боловч графикт ажил 2 сараар хоцорч байгаа. Улсын Комисс хүлээж аваагүй, санхүүжилт бүрэн олгогдсон байна.
7	Хөвсгөл аймгийн ЗДТГ	Соёлын төвийн барилга (Хөвсгөл, Улаан-Уул)	"Синчи Ойл" ХХК	2008-2009	500.0	500.0	108.9	391.1	20	x	x	x		Зураг төсөв болон аймгийн холбогдох мэргэжлийн байгууллагын дүгнэлт удааширнаас тендер шалгарулалт оройтсон. Тендер үнэлэх явцад Үнэлгээний хорооны гишүүний зүгээс гомдол гарснаас үнэлгээ хийх ажиллагаа удааширсан. Анхны зураг өөрчлөгдсөн. Зургийн даалгаварт өгөгдсөн заалтыг зураг гүйцэтгэгч компани дутуу гүйцэтгэсэнээс хугацаа алдсан. Авсан урьдчилгаа хөрөнгөөр суурийн материал татан авалт хийсэн мөн барилгад шаардлагатай дүнг, мод бэлтгэгдсэн байна.

8	Архангай аймгийн ЗДТГ	Цэцэрлэгийн барилга, 50 ортой (Архангай, Батцэнгэл)	"Би Ди Эйч Эс" ХХК	2007-2009	140.0	140.0	140.0	-	80	x	x		Орон нутагт эрх шилжсэн. Анх зураг төсөв хийхдээ гадна шугам сүлжээний ажлын хөрөнгийг тусгаагүй, БУА хийгдэж дууссан, гадна шугам сүлжээгүй тул ашиглалтад аваагүй байгаа. 2010 онд гадна шугам сүлжээнд 45,0 сая төгрөг батлагдсан байна.
9	БСШУЯ	Сургуулийн барилга, 320 суудал, спортын заалны шинэчлэл 12*24м (Баянхонгор, Галуут)	"Материал трейд" ХХК	2008-2009	726.6	726.6	627.5	99.1	80	x			640 суудалтай сургуулийн барилгыг буулгах ажил хийгдэж дууссан. Барилгын талбай цэвдэг хөрстэйн улмаас хуучин барилгын суурийн буулгалтын ажлын графикт хугацаа хойшлогдож 320 суудалтай сургуулийн БУА оройтож эхэлсэн. Үүний улмаас ажил 2009 онд багтаж ашиглалтанд ороогүй. Спорт заалны шинэчлэлийн ажил дууссан. Шинээр баригдах 320 суудалтай сургуулийн барилгын дээврийн ажил хийгдсэн байна. Дотор засал гадна талбайн тохижилт энэ онд хийгдэнэ. Үлдэгдэл хөрөнгийг 2010 оны тодотголд тусгуулахаар санал хүргүүлжээ.
10	Говьсүмбэр аймгийн ЗДТГ	Хүүхдийн цэцэрлэг-яслийн цогцолбор, 100 ортой. (Говьсүмбэр, Сүмбэр)	"Мөнхийн үргэлжлэл" ХХК	2007-2009	223.0	223.0	223.0		70	x	x		2007 онд орон нутагт тендер зарлаж гүйцэтгэгч шалгарсан, 2-р давхарын өрөг дууссан гадна дотоод заслын ажил, дээвэр дутуу, дотор цахилгаан сантехник хийгдээгүй. Үнийн зөрүүнд 216,0 сая төгрөгийг гүйцэтгэгч хүссэн боловч 23,0 сая төгрөг шийдвэрлэгдсэн. Дутагдаж байгаа хөрөнгөөс 40 000 ам долларыг Дэлхийн Зөн олон улсын байгууллагын зүгээс гаргах боломжтой болсон ба үлдэгдэл 133 сая төгрөгийг Я.Батсуурь гишүүний хуваарьт хөрөнгөөс шийдвэрлэжээ.
11	Баянхонгор аймгийн ЗДТГ	Соёлын төвийн барилга, 250 суудал (Баянхонгор, Баян-өндөр)	"Баянтосон" ХХК	2008-2009	296.5	138.5	138.5	-	90				Орон нутагт эрх шилжсэн. Барилгын өрлөгийн ажил дууссан. Засал хийгдэж байна. 2010 онд үргэлжилнэ.
12	Сүхбаатар аймгийн ЗДТГ	Сургуулийн дуусгал (Сүхбаатар, Халзан)	"Их гэрэлтэх" ХХК	2008-2009	232.2	223.5	223.5	-	80	x	x	x	Орон нутаг зураг төсвийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр дур мэдэн батлагдсан зургийг өөрчилж, зоорьтой 2 давхар барилгыг зоорьгүй 3 давхар болгон өөрчилсөн, батлагдсан зургаар ханын хөөсөнцөр 140 мм байхад өөрчилж 100 мм болгосон ба батлагдсан төсвөөс 147,8 сая төгрөгөөр хэтрүүлж гэрээ байгуулсан байна.
13	Төв аймгийн ЗДТГ	Соёл амралтын хүрээлэн (Төв, Лүн)	"Элит хийц" ХХК	2008-2009	500.0	500.0	150.0	350.0	-	x	x	x	2008 онд 150,0 сая.төгрөгөөр барилгын ажлыг эхлүүлсэн (барилга баригдах талбай дээгүүр агаараар татагдсан 2 салаа 0,4кВт-ын шугам трансформаторын хамт шилжүүлэн зөөж, талбайг чөлөөлж хашаа барьсан) боловч 2009 батлагдсан 350,0 сая.төгрөгийн хөрөнгийг аймаг, орон нутгийн удирдлагын зүгээс зориулалтыг өөрчлүүлэх санал гаргаснаас төсөл хэрэгжээгүй байна.
14	Төв аймгийн ЗДТГ	Спорт заал, 12х24м, соёлын төвийн барилга, 200 суудал, (Төв, Баян)	"Сумпакс" ХХК	2007-2009	425.0	325.0	295.0	30.0	90	x	x		Үлдэгдэл хөрөнгө болох 30,0 сая төгрөгийг 2010 оны тодотголд тусгуулахаар санал хүргүүлсэн. Соёлын төвийн барилгыг ашиглалтад өгсөн.
15	БСШУЯ	Сургуулийн барилга, 920 суудал (Улаанбаатар, БГД 1-4 дүгээр хороо)	"Цаст констракшн" ХХК	2008-2010	2,239.1	268.3		268.3	-	x			Газрын зөвшөөрлийн асуудал удааширч, анх олгосон газар хувийн компаний газартай давхацсан, дараа нь олгосон газрын багтаамжаас шалтгаалж хүчин чадлыг бууруулж, 640 суудалтай болгож зураг төсөв хийлгэсэн.Эхний тендерт шаардлага хангасан компани оролцоогүйгээс тендерийг дахин явуулсан. Одоогийн байдлаар гүйцэтгэгч шалгарч гэрээ байгуулсан, ажил 2010 оны 4 дүгээр сараас эхлэнэ.

16	БСШУЯ	Сургуулийн өргөтгөл, спорт заалны барилга, "Монгени" сургууль (УБ)	"МБУ" ХХК	2008-2009	629.0	629.0	293.7	335.3	30	x	x	x	2009 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр ашиглалтад оруулахаар МБУ ХХК-тай гэрээ байгуулсан боловч хэрэгжээгүй байна. Энэ нь тус компани өөрийн гэсэн мэргэжлийн үндсэн ажилчидгүй, техник, хэрэгсэлгүйгээр Барилга угсралтын ажлыг хугацаанд нь гүйцэтгээгүй байна. Анх гүйцэтгэгчийг шалгаруулахдаа ажлын туршлага, санхүү, ажиллах хүч болон техник, тоног төхөөрөмжийн нөөц боломжийг дутуу судалсантай холбоотой байна. Гүйцэтгэгч авсан хөрөнгийнхөө хэмжээний ажлыг гүйцэтгээгүй байна.
17	БСШУЯ	"Алтай" чуулгын байр, (Говь-Алтай)	"Заг" ХХК	2008-2009	1,850.0	1,850.0	1,595.0	255.0	45	x	x		Анх тендерт хэт бага үнийн саналаар орж шалгаран гэрээ байгуулсан, барилгын төсвийг бага үнээр хийсэн, үнийн зөрүү гарсан зэргээс шалтгаалж хугацаандаа ашиглалтанд ороогүй. Үнийн зөрүү 149,1 сая төгрөг гүйцэтгэгч авсан боловч дахин 2.2 тэрбум төгрөг нэхэмжилж байгаа. Хугацаа сунгасан нэмэлт гэрээ хийгдсэн байна.
18	БСШУЯ	Сургуулийн өргөтгөл, 6 анги, дотуур байрны өргөтгөл (Хэнтий, Бор-Өндөр)	"ӨВМТХ" ХХК	2008-2009	729.8	729.8	729.8	-	70	x		x	Тендерийн хуулийг зөрчиж орон нутагт гүйцэтгэгчийг шалгаруулсан. Дотуур байрны 2-р давхарын өрөг хийгдэж байгаа. Сургуулийн өргөтгөлийн барилгын угсралтын ажил хийгдсэн, дотор засал, сантехник, цахилгаан, гадна талбайн тохижилт дутуу, гэрээнд заагдсан ажлыг хийж дуусгахад шаардлагатай хөрөнгө 2010 онд тусгагдсан байна.
19	Хэнтий аймгийн ЗДТГ	Цэцэрлэгийн барилга, 75 ор (Хэнтий, Баян-Овоо)	"Хэнтий Хангай" ХХК	2008-2009	350.0	350.0	350.0	-	65	x	x		Орон нутагт тендер зарлаж гүйцэтгэгч шалгарсан. Барилгын суурь дуусч 2-давхарын хучилт хийсэн. Нэмэлт 150,0 сая төгрөгийн асуудлыг 2010 оны төсвийн тодотголд тусгуулахаар санал хүргүүлсэн.
20	Дорноговь аймгийн ЗДТГ	Сургуулийн барилга, 960 суудал (Дорноговь, Сайншанд)	"Дархан трейд" ХХК	2008-2009	230.0	144.0	144.0	-	35	x	x	x	Орон нутагт эрх шилжсэн. Суурийн ажил хийгдсэн, одоогоор зогсонги байдалтай байна. Орон нутаг батлагдсан төсвөөс хэтрүүлж гэрээ байгуулсан. 2010, 2011 он дамжин хэрэгжихээр болжээ.
21	Дорноговь аймгийн ЗДТГ	Сургуулийн спортын заал, 3 дугаар сургууль (Дорноговь)	"Анар" сан	2007-2009	191.0	191.0	191.0		65	x	x		Орон нутагт эрх шилжсэн. Гүйцэтгэгчид үнийн зөрүү 16.4 сая төгрөг олгогдсон. 2010 онд шилжиж 60.0 сая төгрөг төсөвт батлагдсан. 2010 оны 8-р сарын 25-нд ашиглалтад оруулахаар гэрээний хугацааг сунгасан байна.
22	УБ хот Чингэлтэй дүүрэг	Цэцэрлэгийн барилга, 60 ортой. (УБ, ЧД-ийн 12 дугаар хороо)	"Элком" ХХК	2007-2009	322.8	322.8	322.8	-	60	x			Орон нутагт эрх шилжсэн. Гэрээт хугацаанд ашиглалтад ороогүй.
23	БСШУЯ	Цэцэрлэгийн барилга, 120 ор (Орхон, Баян-Өндөр сумын Шанд баг)	"Төмөр хүлэг" ХХК	2008-2009	598.2	598.2	538.4	59.8	90	x			Орон нутагт эрх шилжсэн. Үлдэгдэл хөрөнгийг 2010 оны тодотголд тусгуулахаар санал хүргүүлжээ.
24	Дорноговь аймгийн ЗДТГ	Хөгжимт драмын "Саран хөхөө" театрын барилга (Дорноговь)	"Рэмугс" ХХК	2008-2009	988.2	988.2	901.9	86.3	90	x	x	x	Зураг төсвийг "ТГТ" ХХК экспертизээр хянуулж батлуулаагүй. Орон нутагт гэрээ байгуулсан боловч 2009 онд БСШУЯ-нд эрх нь шилжиж, 2010 оны 6-р сарын 1-нд ашиглалтад оруулахаар нэмэлт гэрээ байгуулсан. Үлдэгдэл хөрөнгийг 2010 оны тодотголд тусгуулахаар санал хүргүүлжээ.
25	Нийслэл БХБТГ	Цэцэрлэгийн барилга, 100 ор (УБ, БЗД-ийн 5 дугаар хороо)	"СБМ" ХХК	2007-2009	320.9	320.9	320.9	-	90	x		x	Орон нутагт шилжсэн. Гадна бохир усны шугам сүлжээний техникийн нөхцөл буруу гарсан байна.
26	Нийслэл БХБТГ	6 дугаар цэцэрлэгийн өргөтгөлийн барилга (УБ, БЗД)	"Фамили Сон" ХХК	2008-2009	360.0	360.0	360.0		30	x			Орон нутагт шилжсэн. Газар шороо суурийн ажил хийгдэж байна. Батлагдсан төсвөөс хэтрүүлж гэрээг байгуулсан. 2010 онд үлдэгдэл хөрөнгө батлагдсан. 2010 онд ашиглалтанд орно.

27	Нийслэл БХБТГ	Цэцэрлэгийн барилга, 100 ортой (УБ, БЗД, 6 дугаар хороо) Бөхийн өргөө	"Материал трейд" ХХК	2008-2009	323.1	323.1	265.3	57.8	80	x	x	x	Орон нутагт шилжсэн. Барилгын гадна цэвэр усыг хувийн компанийн шугамнаас авахаар техникийн нөхцөл олгогдсон боловч тус компани зөвшөөрөхгүй байгаа.
28	Нийслэл БХБТГ	21 дүгээр цэцэрлэгийн барилгын өргөтгөл (УБ, БЗД, 16 дугаар хороо)	"Конскомм" ХХК	2008-2009	150.0	150.0	150.0	-	60	x	x		Орон нутагт шилжсэн. 2010 онд үлдэгдэл хөрөнгө батлагдсан. 2010 онд ашиглалтанд орно.
29	Булган аймгийн ЗДТГ	Сургуулийн барилгын өргөтгөл, 6 анги (Булган, Баян-Агт)	"Төмөр бетон хийц" ХХК	2008-2009	318.4	318.4	318.4		90	x	x		Орон нутагт эрх шилжсэн, нэмэлт хөрөнгө шаардагдаж байгаа.
30	Хөвсгөл аймгийн ЗДТГ	Сургуулийн барилгын өргөтгөл (Хөвсгөл, Арбулаг)	"Урагшлах" ХХК	2008-2009	280.0	278.9	278.9		65	x			Орон нутагт эрх шилжсэн. Геологийн шинжилгээний дүгнэлт алдаатай гарснаас хугацаа алдсан. Ажил үргэлжилж байгаа.
31	Хэнтий аймгийн ЗДТГ	Соёлын төвийн барилгын дуусгал (Хэнтий, Баян-Овоо)	"Нью констракшн" ХХК	2008-2009	116.9	116.9	116.9		65	x	x		Орон нутагт тендер зарлаж гүйцэтгэгч шалгарсан 2007 онд улсын төсвийн хөрөнгөөр эхлээд 90 сая төгрөг авч газар шорооны ажил хийгдсэн. 2008 онд 30 сая төгрөг санхүүжиж суурь хийгдэж өрөг 50 хувь хийгдсэн. 2009 онд 56,9 сая төгрөгөөр ханын өрөг, туслах барилгын хучилт, багана хийгдсэн. Одоо хийгдэх ажил: Заалны барилгын хучилтын ажил, хаалга, цонх суулгах сантехник, цахилгаан, шал, гадна дотор засал. Татсан материал: Дээврийн дам нуруу, сендвич хавтан талбай дээр татсан. Үнийн зөрүүгээр 8.0 сая төгрөг шийдвэрлэсэн. Гүйцэтгэгч авсан хөрөнгөөр барилга дуусах боломжгүй хэмээн шаардлагатай хөрөнгийн тооцоог 101.8 сая төгрөг гэж гаргасан байна.
32	Архангай аймгийн ЗДТГ	Цэцэрлэгийн барилга, 50 ортой (Архангай, Цэцэрлэг)	"Аяа" ХХК	2008-2009	262.9	262.9	262.9		70	x	x		Орон нутагт эрх шилжсэн. 50 ортой цэцэрлэг баригдахаар ажил эхэлсэн боловч Н.Батбаяр гишүүний хүсэлтээр хүчин чадлыг 100 ортой болгож нэмэгдүүлснээс суурийг томсгон гүйцэтгэсэн. 2010 онд шаардлагатай хөрөнгө нь тусгагдсан байна.
33	ЗТБХБЯ (автозам)	БНСУ-ын зээлээр хэрэгжүүлэх "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл"-ийн Чойр-Сайншанд чиглэлийн 176.4 км	"Ханшин" ХХК	2007-2010	8270.3	3,000.0		3,000.0			x		Төслийн хүрээнд Солонгосын эдийн засгийн хамтын ажиллагааны банкны санхүүжилтээр 176.4 км автозам баригдах бөгөөд Солонгосын Ханшин Инженеринг компанийн гэрээг цуцалсан. Тус компани нь гэрээт хугацаандаа ажлаа гүйцэтгээгүй байна.
34	ЗТБХБЯ (автозам)	АХБ-ны зээлээр хэрэгжүүлэх "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл"-ийн Сайншанд-Замын Үүд чиглэлийн хатуу хучилттай зам	"Чайна Жео Инженеринг" ХХК	2006-2009	3360.7	1,670.4	172.9	1,497.5	10	x		x	Гэрээт хугацаанд ажил хийгдээгүй гол шалтгаан нь захиалагчийн зүгээс гаргах шийдвэр удааширалтай, хүн, хүч, тоног төхөөрөмж оруулж ирэхэд хугацаа алдсанаас болжээ. Нөгөө талаар СЯ, ГЕГ-аас гадаадаас оруулах техник, тоног төхөөрөмж оруулах зөвшөөрөл, НХХЯ нь гадаадаас хүн хүчийг оруулж ирэх зөвшөөрлийн шийдвэрийг ЗГ-аар батлуулахын тулд ихээхэн цаг хугацаа алдсан байна.
35	ЗТБХБЯ (автозам)	АХБ-ны зээлээр хэрэгжүүлэх "Бүс нутгийн авто зам хөгжүүлэх төсөл"-ийн Сайншанд-Замын-Үүд чиглэлийн 62 км хатуу хучилттай зам	"Шинли Гүнчин" ХХК	2007-2009	1560.0	813.9	501.8	312.1	30	x		x	Гэрээт хугацаанд ажил хийгдээгүй гол шалтгаан нь захиалагчийн зүгээс гаргах шийдвэр удааширалтай, хүн, хүч, тоног төхөөрөмж оруулж ирэхэд хугацаа алдсанаас болжээ. Нөгөө талаар СЯ, ГЕГ-аас гадаадаас оруулах техник, тоног төхөөрөмж оруулах зөвшөөрөл, НХХЯ нь гадаадаас хүн хүчийг оруулж ирэх зөвшөөрлийн шийдвэрийг ЗГ-аар батлуулахын тулд ихээхэн цаг хугацаа алдсан байна.

36	ЗТБХБЯ (автозам)	АХБ-ны буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх "Баруун бүс-Алтайн зам хөгжүүлэх төсөл"-ийн Ховд аймгийн Булган сумын Тэмээн хүзүү-Бага улаан даваа, Бага улаан даваанаас Манхан сум хүртэлх хатуу хучилттай зам		2009-2012	19292.4	1,690.9	1,690.9			x				Төслийн хүрээнд баригдах зам барилгын ажилд хяналт тавьж, зөвлөхийн үйлчилгээ үзүүлэхээр БНСУ-ын Korea Consultants International Co.Ltd компани шалгарч ЗТБХЯ-тай гэрээ байгуулсан. Гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажил явагдаж байна.
37	ЗТБХБЯ (автозам)	Ховдын Булган-Үенч-Ховд чиглэлийн -40 км хатуу хучилттай авто зам	"Читай" ХХК	2007-2009	6800.0	1,471.1	690.9	780.2	10	x	x		x	Төлөвлөгдсөн хөрөнгөө бүрэн гүйцэд ашиглаж чадаагүй, гэрээний үүргээ биелүүлээгүй байна.
38		-20 км хатуу хучилттай авто зам	"Читай" ХХК	2008-2010	3849.0	1,500.0	874.0	626.0	20	x	x		x	
39	ЗТБХБЯ (автозам)	Улаангом-Тээлийн 15 км хатуу хучилттай авто зам	"Хотгор" ХХК	2008-2009	3000.0	2,500.0	1,571.6	928.4	50	x	x			Хүчин чадал нь хүрэлцээгүй, инженер техникийн ажилтан дутагдалтай байна.
40	ЗТБХБЯ (автозам)	Хануйн голын төмөр бетон гүүр-Халзанбургэдэй чиглэлийн 65.3 км хатуу хучилттай зам (Катарын тусламж)	"Хурдны зам" ХХК, "Монроуд" ХХК	2008-2010	11680.0	5,424.9	5,360.9	64.0	50	x	x		x	"Монруд" ХХК төлөвлөгдсөн хөрөнгөө давуулж биелүүлсэн, 5 км замд "Хурдны зам" ХХК хугацаандаа ажлаа хийгээгүй, тоног төхөөрөмж хуучин, саатал гарсан зэргээс шалтгаалжээ.
41	ЗТБХБЯ (автозам)	Хөвсгөл аймгийн Мөрөн сумын төвийн 1.1 км автозамын сүлжээний өргөтгөл	"Композит-Асмо" ХХК, "Хөвсгөл зам" ХХК	2008-2009	301.6	166.4	102.6	63.8	30	x				Композит-Асмо ХХК-ний гүйцэтгэж байгаа замын ажлын траст байгаа айлууд газар чөлөөлөхгүй удсан."Хөвсгөл зам" ХХК-ны гадаадаас оруулж ирсэн битум ашиглах боломжгүй гэсэн дүгнэлт гарч дахин өөр улсаас битум нийлүүлэгдэх болсноос хугацаа алдсан байна.
42		Аймгийн төвүүдийн автозамын шинэчлэлт, 18 аймаг		2008-2009	340.0	23.8	23.8	23.8	x					
43		УБ-Эрдэнэсантын 168.2 км хатуу хучилттай авто зам	"Очир төв" ХХК, "Монроуд" ХХК	2007-2008	34355.2	369.3	369.3			x			x	Гүйцэтгэгч хугацаа алдсан, ажил нь зураг төсөл, техникийн шаардлага бүрэн хангаагүй гэж захиалагч нь үзсэн байна.
44		Хиймэл дагуулын холбооны систем	"Орбитнет" ХХК	2008-2009	988.2	488.2	399.0	89.2	100	x				Улсын комисс хүлээн аваагүй байхад санхүүжүүлсэн байна.
45	ИНЕГ	Нисэх буудлын онгоц хөөрч, буух хатуу хучилттай зурвас, үерийн далан (Завхан, Улиастай)	"Хурдны зам" ХХК	2008-2010	8651.5	4,500.0	4,326.5	173.5	50	x				Гүйцэтгэл дутуу байхад санхүүжүүлсэн байна.
46		Баянголын амны орон сууцны хорооллыг дулааны эх үүсвэртэй холбох инженерийн шугам сүлжээ, III ээлж (УБ)	"Оджон холдинг" ХХК	2008-2009	3211.9	2,434.9	2,087.7	347.2	60	x	x			Шугамын трассын дагууд УБтөмөр замын газартай Түшиг -Уул ХХК нь гэрээ байгуулан салаалсан төмөр зам түрээслэн эзэмшиж байгаа цэгт төмөр зам нэвтрэн гарах асуудал гарч түүний шийдвэр хүлээгдсэн тул ажил явуулах боломж алдагдсан . УБ төмөр замын газраар зураг төслийн ажил хийгдэж
47	ЗТБХБЯ (барилга)	Дорноговь аймгийн Сайншанд хотод баригдсан 20 айлын орон сууцны гадна инженерийн шугам сүлжээний ажил	"Монхидро констракшн" ХХК	2009	1215.6	1,215.6	1,204.2	11.4	100	x			x	Хугацаандаа ажил хийгдээгүй, ажиллах хүч нэмж шаардагдсан байна.
48		АХБ-ны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй "Хот байгуулалтын салбар"-ын төслийн дотоод эх үүсвэр	Хот байгуулалтын салбарын төсөл	2009-2011	2741.7	900.0	78.4	821.6		x			x	Төслийн ажил хугацаандаа хийгдээгүй нүүлгэн шилжүүлэх ажил удааширсан байна

49		Өгийнуур-Хөшөөцайдам чиглэлийн 10 км хатуу хучилттай зам	"Саруул жим" ХХК	2007-2009	1298.9	280.1	280.0	0.1	20	x				Шууд гэрээ байгуулсан аймаг сумын удирдлагаас нөхцөл бололцоог хангаж өгөөгүйгээс хугацаа алдсан.Мөн хөрөнгө дутуу төлөвлөгдсөн шалтгаанаар ажил нь удааширсан байна.
50	ЗТБХБЯ (авто зам)	Хархорин-Цэцэрлэгийн 74 км хайрган замыг хатуу хучилттай болгох	"Авто зам" ХХК	2007-2009	8403.6	1,955.8	223.8	1,732.0		x			x	Шууд гэрээ 5 гүйцэтгэгч компанитай байгуулсан, үүнээс "Нутгийн зам" ХХК, "Асби" ХХК-ийн 29.9 км замын гэрээ цуцлагдсан, "Ялгуулсан", "Бөөн улиас" ХХК-иуд нь 27.1 замыг барьж 2008 онд ашиглалтад оруулсан, үлдсэн 10 км замыг "Архангай авто зам" ХХК барьж байна .Тоног төхөөрөмж дутагдалтай байна.
51		Цэцэрлэг-Их тамир-Тосонцэнгэл чиглэлийн 53 км хайрган замыг хатуу хучилттай болгох	"Хурдны зам" ХХК	2007-2009	8296.0	1,528.2	728.9	799.3	10	x	x		x	Шууд гэрээ байгуулсан.38 км хайрган замыг "Хурдны зам " ХХК барьж байгаа.
